PAPER WORKING PAPER WORKING PAPER WORKING PAPER WORKING PAPER W

# "МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИУДЫН ҮР ДҮНД ХИЙХ ШИНЖИЛГЭЭ"

Б.ЭРДЭНЭДАЛАЙ

УЛС ТӨР СУДЛААЧ, ДОКТОР
МУИС-ИЙН УЛС ТӨР СУДЛАЛЫН ТЭНХИМИЙН АХЛАХ БАГШ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ
2021 ОН

© Энэхүү бүтээлийг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй "Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд бүтээв.

Бүтээлд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь уг бүтээлийн зохиогчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын Засгийн газар, эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.

USAID FROM THE AMERICAN PEOPLE · IRI INTERNATIONAL REPUBLICAN INSTITUTE · The Asia Foundation

АГУУЛГА

НЭГ. ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ УЛСУУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТИЙН ОНЦЛОГ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ТОЙМ АНАЛИЗ ..... 3

А. ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ УЛСУУДЫН ХУУЛЬ САНААЧЛАХ ЭРХТЭЙ СУБЪЕКТ ..... 4

Б. ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ОРНЫ ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ БҮРЭН ЭРХ 7

В. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛИАР ОЛГОСОН БҮРЭН ЭРХ ..... 7

ХОЁР. ..... 10

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ОРОЛЦОО ..... 11

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ ..... 23

САНАЛ: ..... 24

ХАВСРАЛТ ..... 25

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Парламентын засаглалтай улсуудын хууль санаачлах эрхтэй субъект ........... 5
Хүснэгт 2. Монгол Улсын Ерөнхийлөгч нарт хуулиар олгосон эрхүүд .......................... 10
Хүснэгт 4. Сонгогчдын оролцоонд нөлөөлж буй макро эдийн засгийн үзүүлэлтүүд..... 13
Хүснэгт 5. Ерөнхийлөгчийн сонгууль ба УИХ-ын сонгууль ........................................... 14
Хүснэгт 6. Нэр дэвшигчийн авсан санал ба хувийн мэдээлэл хоорондын хамаарал ...... 19
Хүснэгт 7. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн харьцуулалт.................................... 21

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сонгогчдын оролцоо: Орон нутаг ба Улаанбаатар хот ....................................... 11
Зураг 2. Сонгогчдын оролцоо: Аймгаар ............................................................................. 12
Зураг 3. Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн: Нэр дэвшигчдээр .................................... 14
Зураг 4. Хүчингүй эсвэл цагаан саналын нийт саналд эзлэх хувь .................................. 15
Зураг 5. Хүн амын цэвэр шилжилт...................................................................................... 15
Зураг 6. Хэвлэлийн мониторинг: 2009 ба 2017 оны дүн ................................................... 16
Зураг 7. Санал ба хэвлэлд цацагдсан хугацаа хоорондын хамаарал................................. 16
Зураг 8. Нэр дэвшигчдийн орлогын задаргаа: 2009-2017 он ............................................ 17
Зураг 9. Нэр дэвшигчдийн зардлын задаргаа: Нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал ба бусад зардлын харьцаа (2009 ба 2017 он) ........................................................................................................................ 17
Зураг 10. Нэр дэвшигчдийн зардал ба авсан санал хоорондын хамаарал ....................... 18
Зураг 11. Сонгуулийн ирц ба ялсан нэр дэвшигчийн авсан санал .................................. 19

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1990 онд Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 30 жил өнгөрч байна. Аливаа улсын ардчиллын чанар, бэхжилтийг хангахад төрийн байгууллын тогтолцоо, институтүүд хамгийн чухал үүрэгтэй. Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан төрийн байгууллын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх тогтолцоотой байхын сацуу Ерөнхийлөгчийн институттэй улс болсон. Монголын улс төрд Ерөнхийлөгчийн үүрэг, оролцоо тогтмол гол нөлөөлөгч байсаар ирсэн бөгөөд нийт иргэдийн шууд сонгуулиас сонгогддог гэдгээрээ өвөрмөц юм.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 1993 оноос хойших Монгол Улсад болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулиудын үр дүнд харьцуулсан шинжилгээ хийж, Ерөнхийлөгчийн сонгуулийн онцлог, сонгуулийн үр дүнд нөлөөлөгч хүчин зүйлс, тогтмол өсөж буй сонгуулийн кампанит ажлын зардлын дүн зэрэгт хамаарал бий, эсэхийг Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Улсын дээд шүүх зэрэг байгууллагын албан ёсны дүн мэдээнд үндэслэн дата статистикийн шинжилгээ хийхийг зорьж байна.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж, хэрэгжүүллээ. Үүнд:

- Парламентын засаглалтай улсуудын Ерөнхийлөгчийн институтийн онцлог, эрх зүйн зохицуулалтад тойм анализ хийх.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бодит буюу боломжит мэдээллүүдийг тодорхойлох, түүнийг судлан шинжилгээ хийх.
- Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах, ингэхдээ сонгуулийн кампанит ажлын зардал болон сонгогдох магадлалын хамаарлыг тодорхойлох.
- Дээрх харьцуулалт шинжилгээнд үндэслэн нөхцөл байдлыг сайжруулах, түүнд нөлөөлөх судалгааны санал, зөвлөмж боловсруулах.

***Судалгааны арга***

Энэхүү судалгааг хийхдээ судалгааны анхдагч (хууль, дүрэм, журам, шийдвэр) болон хоёрдогч (Ерөнхийлөгчийн институтийн талаарх судалгааны бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, статистик) эх сурвалжийн агуулгад дүн шинжилгээ хийх, контент анализ, статистик шинжилгээнд тулгуурлах, ажиглалт, кейс судалгаа болон харьцуулах аргуудыг голлон хэрэглэлээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## НЭГ. Парламентын засаглалтай улсуудын Ерөнхийлөгчийн институтийн онцлог, эрх зүйн зохицуулалтад хийсэн тойм анализ

Парламентын засаглалтай улсуудын хууль санаачлах эрхтэй субъектүүдийн талаар тухайн улсын Үндсэн хуулийн зохицуулалтуудыг судаллаа. Ингэхдээ парламентын хаант засаглалтай орнуудаас Испани, Их Британи, Япон, харин

парламентын бүгд найрамдах улсуудаас БНХАУ, Болгар, Исланд, Итали, Киргиз, Латви, Македон, Монтенегро, Серби, Сингапур, Словак, Турк, Унгар, Финланд, Хорват, Эстони улсыг хамруулав.

Мөн судалгаанд хамрагдсан орнуудын Төрийн тэргүүний бүрэн эрхүүдийг харьцууллаа. Ингэхдээ парламентын хаант болон бүгд найрамдах засаглалтай 19 орны Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид Төрийн тэргүүн (ерөнхийлөгч, хаан)-ий эрхийг Үндсэн хуулийн холбогдох заалттай харьцуулав.

Дэлхийн улс орнууд засаглалын хэлбэрээс хамаараад Ерөнхийлөгч, Хаан, Төрийн тэргүүн нь харилцан адилгүй эрх мэдэлтэй байдаг. Монгол Улсын хувьд парламентын засаглалтай боловч зарим судлаач Ерөнхийлөгчид хэт их эрх мэдлийг Үндсэн хуулиас гадуур бусад хуулиар олгосоор ирсэн гэж үздэг. Энэ ч үүднээс манай улсыг хагас Ерөнхийлөгчийн засаглалтай хэмээн ойлгодог хэсэг байв. Харин 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулиас бусад хуулиар Ерөнхийлөгчид шинээр эрх нэмж хуульчлахыг хязгаарласан зохицуулалт тусгасан.

### А. Парламентын засаглалтай улсуудын хууль санаачлах эрхтэй субъект

Судалгаанд хамруулсан парламентын хаант болон парламентын Бүгд найрамдах улсад хууль санаачлах эрх бүхий субъект харилцан адилгүй байна. Эдгээр 19 орноос:

- Төрийн тэргүүн (Ерөнхийлөгч, Хаан) нь хууль санаачлах эрхгүй улс - 14 (БНХАУ, Испани, Итали, Их Британи, Киргиз, Македон, Серби, Сингапур, Словак, Турк, Финланд, Хорват, Монтенегро, Япон);
- Ерөнхийлөгч зөвхөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачлах эрхтэй улс - 2 (Болгар, Эстони);
- Ерөнхийлөгч хууль санаачлах бүрэн эрхтэй улс - 4 (Латви, Исланд, Унгар, Монгол).

Дараах хүснэгтэд харьцуулсан орнуудаас Ерөнхийлөгч, парламентыг нийтээрээ сонгодог Монгол Улстай ижил төстэй сонгуулийн тогтолцоо бүхий 11 улс (Болгар, Исланд, Киргиз, Македон, Сингапур, Серби, Словак, Турк, Финланд, Хорват, Монтенегро) байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бие даан хэрэгжүүлдэг 20 бүрэн эрх байгаагаас “Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх” Латви, Унгар, Исланд, Монгол Улсад байх бөгөөд бусад 10 орны Ерөнхийлөгч нь хууль санаачлах эрхгүй. Харин “Уучлал үзүүлэх эрх” нь 11 орны Ерөнхийлөгчид олгогдсоноороо нийтлэг ажээ. Бусад 11 бүрэн эрхийн хувьд улс орон бүрд харилцан адилгүй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 1. Парламентын засаглалтай улсуудын хууль санаачлах эрхтэй субъект

| | | |
|---|---|---|
| **Парламентын хаант засаглалтай улсууд** | | |
| 1 | Испани | Танхимууд;<br>Өөртөө засах эрх бүхий мужийн парламент;<br>Засгийн газар;<br>500 мянгаас доошгүй иргэд нэгдэж хууль санаачлах эрх эдэлнэ[1];<br>Доод танхим Сенатын хоригийг энгийн олонхын саналаар хэрэгсэхгүй болгож болно. |
| 2 | Их Британи | Танхимын гишүүд хууль санаачлах эрхтэй ба долоон хоногт 1 өдөр хуулийн төсөл өргөн барих эрхтэй.<br>Засгийн газрын гишүүн төлөөлөгч хэдийд ч хуулийн төсөл өргөн барих давуу эрхтэй. |
| 3 | Япон | Ерөнхий сайд Засгийн газрыг төлөөлөн хуулийн төсөл өргөн барина.[2]<br>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг парламент санаачилна. |
| **Парламентын бүгд найрамдах улсууд** | | |
| 4 | БНХАУ | Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (Парламент)-ын бүх төлөөлөгч;<br>Байнгын хороо (Standing committee)-ны бүх төлөөлөгчид[3] хууль санаачлах эрхтэй;<br>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг БХАТИХ-ын төлөөлөгчдийн 1/5-ээс дээших нь санаачлах эрхтэй. |
| 5 | Болгар | Парламентын гишүүн;<br>Сайд нарын Зөвлөл (Засгийн газар);<br>Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Үндэсний Ассамблей 1/2 гишүүд, эсхүл Ерөнхийлөгч санал оруулна[4]. |
| 6 | Исланд | Ерөнхийлөгч нь хуулийн төсөл болон бусад шийдвэрийн төслийг парламентад өргөн барих эрхтэй байна;<br>Парламентын гишүүн;<br>Сайд нар хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхтэй[5]. |
| 7 | Итали | Засгийн газар;<br>Парламентын гишүүд; |

[1] Испанийн Үндсэн хуулийн 87 дугаар зүйл.
[2] Японы Үндсэн хуулийн 72 дугаар зүйл.
[3] БНХАУ-ын Үндсэн хуулийн 72 дугаар зүйлд "to submit bill" буюу хуулийн төсөл өргөн барих эрх нь зөвхөн АТИХ болон Байнгын хорооны гишүүдэд байна. Харин 72 болон 89.2. дах заалтуудад байх "to submit proposal" гэдэг нь хуулиар өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээний асуудлаар санал өргөн барина гэж ялгаатай заасныг анхаарах. www.constituteproject.org/constitution/China_2004?lang=en
[4] Болгарын Үндсэн хуулийн 154 дүгээр зүйл.
[5] Исландын Үндсэн хуулийн 38 дугаар зүйл.

| | | |
|---|---|---|
| | | 50 000-аас багагүй сонгогч гарын үсгээ цуглуулан хуулийн төсөл боловсруулах замаар хууль санаачлах эрхтэй[6].<br>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд эрх бүхий хуулийн этгээд болон сонирхогч талууд оролцох эрхтэй. |
| 8 | Киргиз | Засгийн газар;<br>Парламентын гишүүн;<br>10 000 сонгогч хууль санаачлах эрхтэй[7]. |
| 9 | Латви | Ерөнхийлөгч;<br>Засгийн газар;<br>Сеймийн хороод;<br>Сеймийн таваас доошгүй гишүүд;<br>Нийт сонгогчийн 1/10 хууль санаачлах эрхтэй. |
| 10 | Македон | Засгийн газар;<br>Парламентын гишүүн;<br>10 000 сонгогч хууль санаачлах эрхтэй[8]. |
| 11 | Монтенегро | Засгийн газар;<br>Парламентын гишүүн;<br>6000 сонгогч өөрсдийн итгэмжилсэн парламентын гишүүнээр дамжуулан[9] хууль санаачлах эрхтэй. |
| 12 | Серби | Парламентын гишүүн;<br>автономит мужуудын Ассамблей;<br>30 000 сонгогч;<br>Иргэний хамгаалагч болон Сербийн Үндэсний Банк нь өөрийн эрх мэдэлд хамаарах асуудлаар хууль өргөн мэдүүлэх эрхтэй байна. |
| 13 | Сингапур | Парламентын гишүүн хууль санаачлах эрхтэй[10]. |
| 14 | Словак | Засгийн газар;<br>Үндэсний зөвлөлийн байнгын хороод;<br>Парламентын гишүүн хууль санаачлах эрхтэй[11]. |
| 15 | Турк | Сайд нарын зөвлөл (Засгийн газар);<br>Парламентын гишүүн хууль санаачлах эрхтэй[12]. |
| 16 | Унгар | Ерөнхийлөгч;<br>Засгийн газар;<br>Үндэсний Ассамблейн хороо;<br>Үндэсний Ассамблейн гишүүн хууль санаачлах эрхтэй. |
| 17 | Финланд | Засгийн газар; |

[6] Италийн Үндсэн хуулийн 71 дугаар зүйл.
[7] Киргизийн Үндсэн хуулийн 79 дугаар зүйл.
[8] Македоны Үндсэн хуулийн 71 дугаар зүйл.
[9] Монтенегрогийн Үндсэн хуулийн 93 дугаар зүйл.
[10] Сингапурын Үндсэн хуулийн 59 дугаар зүйл.
[11] Словакийн Үндсэн хуулийн 87 дугаар зүйл.
[12] Туркийн Үндсэн хуулийн 88 дугаар зүйл.



UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | Парламентын гишүүд[13];<br>Зөвхөн ард нийтийн санал асуулгатай холбоотойгоор 50 000-аас доошгүй, сонгуулийн насанд хүрсэн Финланд иргэн[14] хууль санаачлах эрхтэй. |
| 18 | Хорват | Парламентын гишүүд;<br>Парламентын аливаа бүлгийн төлөөлөл;<br>Парламентын хороод;<br>Засгийн газар хууль санаачлах эрхтэй[15]. |
| 19 | Эстони | Парламентын гишүүд;<br>Парламентын бүлэг;<br>Засгийн газар;<br>Ерөнхийлөгч зөвхөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачлах эрхтэй[16]. |

### Б. Парламентын засаглалтай орны Төрийн тэргүүний бүрэн эрх

Монгол Улсын Үндсэн хуульд заасан, Ерөнхийлөгчийн бусад субъекттэй хамтран хэрэгжүүлдэг эрхийг дээрх орнуудаас Ерөнхийлөгч, парламентыг (парламентын нэг танхимтай) бүх нийтээр сонгодог Монгол Улстай ижил төстэй сонгуулийн тогтолцоо бүхий 11 улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хэрхэн заасныг харьцуулсан (Ариунаа.Ц. Парламентын судалгааны хүрээлэн) судалгаа байдаг. Энэхүү харьцуулалтаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн хамтран хэрэгжүүлдэг найман эрх байгаагаас “Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрх” эдгээр 11 улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна. Бусад долоон эрхийн хувьд улс орон бүрд харилцан адилгүй байна. Хавсралт 1-ээс харна уу.

### В. Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон бүрэн эрх

Судалгааны энэ хэсгийн хүрээнд 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш 2020 оны арванхоёрдугаар сарын 31 хүртэлх хугацаанд батлагдсан бүх хуулиудад Монгол Улсын Ерөнхийлөгч[17]-ийн бүрэн эрхийг хэрхэн тусгасныг шүүн судаллаа.

Судалгааны үр дүнд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль[18]-аас гадна давхардсан тоогоор нийт 107 хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчид тодорхой эрхүүдийг олгосон байна. Үүнд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 64 хууль, хүчингүй болсон 43 хууль багтаж байна. Ерөнхийлөгчид бусад

[13] Финландын Үндсэн хуулийн 70 дугаар зүйл.
[14] Финландын Үндсэн хуулийн 53 дугаар зүйл.
[15] Хорватын Үндсэн хуулийн 85 дугаар зүйл.
[16] Эстонийн Үндсэн хуулийн 103 дугаар зүйл.
[17] https://president.mn/
[18] https://www.legalinfo.mn/law/details/338

хуулиар олгосон бүрэн эрхүүдийг жагсаахдаа одоо ажиллаж буй Ерөнхийлөгчийн хүрээнд судалсан судалгаа[19]-ны үр дүнгээс авлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчид эрх олгосон хуулийн заалтуудыг дараах байдлаар ангилсныг хавсралт хэсэгт оруулсан болно.

- Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон **үндсэн бүрэн эрх** (Хавсралт 2)
- Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон **бусад бүрэн эрх** (Хавсралт 3)
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгогдсон **бүрэн эрх** (Хавсралт 4)
- Бусад хуулиар олгогдсон **бүрэн эрх** (Хавсралт 5)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг “үндсэн”, “тодорхой” хэмээн ялгах бөгөөд Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасныг “үндсэн” бүрэн эрх, үндсэн эрхийн хүрээнд бусад хуулиар олгосон эрхийг “тодорхой” бүрэн эрх гэж ойлгоно.[20]

Судалгаанаас үзэхэд, Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-д Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг тогтоосон 12 заалт, эдгээрээс дийлэнх олонх буюу есөн бүрэн эрх нь гүйцэтгэх засаглалтай, бусад бүрэн эрх нь Улсын Их Хурал[21] болон Шүүх эрх мэдэлтэй харилцахтай холбоотой эрх хэмжээ юм.

Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4-т заасан тодорхой бүрэн эрхүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай болон бусад хуулиар тогтоосон. Үндсэн хуулийн энэхүү заалтад 2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд үүнээс үүдэн зарим хуулиар олгогдсон тодорхой эрхүүдийг хасах шаардлага тулгарсан байна.

Үндсэн хуулийн 33.4-т заасан Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиас гадна давхардсан тоогоор нийт 107 хуульд хуульчилж өгсөн. (Хүснэгт 4) Үүнд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 64 хууль, хүчингүй болсон 43 хууль багтаж байна.

Судалгаанаас үзэхэд Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид дараах үндсэн бүрэн эрхийг олгосон байна. Үүнд:

1) бэлгэ тэмдгийн шинжтэй;
2) хууль тогтоомжтой холбогдох;
3) гадаад харилцаанд хамаарах;
4) батлан хамгаалахтай холбоотой;
5) хууль тогтоогчийг тараах;
6) гүйцэтгэх засаглалтай;
7) бусад бүрэн эрх хэмээн тодорхойлж болно.

Дээрх бүрэн эрхийг тус бүрд нь авч үзвэл:

**1) Бэлгэ тэмдгийн шинжтэй чиг үүрэг:** Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол Төрийн тэргүүн, Монголын ард түмний эв

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

---

[19] Ариунаа.Ц. Парламентын судалгааны хүрээлэн
[20] Монгол Улсын Үндсэн хуулийн 33.1, 33.4 дэх хэсэг.
[21] http://parliament.mn/

нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэсэн нь засаг төр, нийгмийн тогтолцоонд түүний эрх зүйн байдлыг илэрхийлсэн гол тодорхойлолт юм. Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг бүхнээс дээгүүр тавьж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилцөлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Энэ ч үүднээс бэлгэ тэмдгийн төдий ухагдахуун биш, засаглах эрх мэдлийн бүх салбарын тэнцвэрт харилцааг гагнан бэхжүүлж засаглах эрх мэдлийг бодитой биечлэн хэрэгжүүлэгч юм. Ийнхүү Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүний хувьд төрийн бусад бэлгэ тэмдгээс ч илүү тухайн улсыг төлөөлж, улсын эв нэгдлийн бэлгэ тэмдэг болж байдаг.

**2) Хууль тогтоомжтой холбогдох бүрэн эрх:** Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт Ерөнхийлөгч УИХ-аас баталсан хуульд бүхэлд нь буюу аль нэг бүлэг зүйл, хэсэгт нэг удаа хориг тавих эрхтэй бөгөөд хууль буюу шийдвэрт тавьсан хоригийг УИХ хүлээн авмагц хэлэлцэх асуудлын ээлж дугаар хүлээхгүй нэн даруй хэлэлцэж, хүлээн авах, эсэхийг шийдвэрлэнэ. УИХ-ын гишүүдийн олонх хоригийг хүлээн аваагүй тохиолдолд хууль батлагдан гардаг. Мөн Үндсэн хууль зөрчсөн, эсэх талаар Цэцэд хянуулахаар хүсэлт гаргах, өөрийн бүрэн эрхэл хамаарах асуудлаар хууль санаачлах зэрэг эрхийг эдэлдэг.

**3) Гадаад харилцаанд хамаарах бүрэн эрх:** Ерөнхийлөгч нь гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, УИХ-тай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах, Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг УИХ-тай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах зэрэг, Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах бүрэн эрхтэй байдаг.

**4) Батлан хамгаалахтай холбоотой бүрэн эрх:** Ерөнхийлөгч Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг тэргүүлдэг эрхтэйн хувьд нийгмийн болон улсын аюулгүй байдлыг хангах, хууль ёс, дэг журмыг бэхжүүлэх талаар хууль тогтоомжийн заалтын хүрээнд бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах, онц болон дайны байдал зарлах зэрэг бүрэн эрхтэй.

**5) Хууль тогтоогчийг тараах бүрэн эрх:** Ерөнхийлөгч парламентыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл УИХ-ын даргатай зөвшилцсөний үндсэн дээр тараах санал УИХ-д тавьж болно. Үндсэн хуульд “УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно” гэж заажээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах шийдвэр гаргах эрхтэй байгаа нь хууль тогтоогчид Ерөнхийлөгчийн зүгээс тавих томоохон хяналтын хэлбэр мөн.

**6) Гүйцэтгэх засаглалтай холбоотой бүрэн эрх:** Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх нь үндсэн бүрэн эрхэд хамаарна.

**7) Бусад бүрэн эрх:** Мөн тодорхой салбарт гавьяа байгуулсан, амжилт бүтээлтэй ажилласан хүмүүсийг урамшуулан шагнах, цол, медалиар шагнах, улс, цэргийн дээд цол хүртээх эрхийг Ерөнхийлөгчид олгосон. Түүнчлэн уучлал үзүүлэх, Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад оргонох эрх олгох гэх мэт бүрэн эрхийг Үндсэн хуульд тусгасан байна.

Хүснэгт 2. Монгол Улсын Ерөнхийлөгч нарт хуулиар олгосон эрхүүд[22]

*2020.12.31-ний байдлаар*

<table>
<tr><th rowspan="3">№</th><th rowspan="3">Монгол Улсын Ерөнхийлөгч</th><th rowspan="3">Бүрэн эрхийн хугацаа</th><th colspan="3">Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн тоо</th><th rowspan="3">Монгол Улсын Ерөнхийлөгчид бүрэн эрх олгосон хуулийн тоо</th></tr>
<tr><th colspan="2">Үндсэн хуулиар олгосон</th><th rowspan="2">Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон эрх</th></tr>
<tr><th>үндсэн бүрэн эрх</th><th>бусад бүрэн эрх</th></tr>
<tr><td>1</td><td>Пунсалмаагийн Очирбат</td><td>1993-1997</td><td>12</td><td>13</td><td>40</td><td>31</td></tr>
<tr><td rowspan="2">2</td><td rowspan="2">Нацагийн Багабанди</td><td>1997-2001</td><td>12</td><td>13</td><td>40</td><td>11</td></tr>
<tr><td>2001-2005</td><td>12</td><td>13</td><td>41</td><td>16</td></tr>
<tr><td>3</td><td>Намбарын Энхбаяр</td><td>2005-2009</td><td>12</td><td>13</td><td>41</td><td>10</td></tr>
<tr><td rowspan="2">4</td><td rowspan="2">Цахиагийн Элбэгдорж</td><td>2009-2013</td><td>12</td><td>13</td><td>41</td><td>10</td></tr>
<tr><td>2013-2017</td><td>12</td><td>13</td><td>42</td><td>16</td></tr>
<tr><td>5</td><td>Халтмаагийн Баттулга</td><td>2017 оноос хойш</td><td>11</td><td>13</td><td>41</td><td>13</td></tr>
</table>

Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон бүрэн эрхүүдийг харьцуулан судалгааг Хавсралтаас үзнэ үү.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ХОЁР.**

- **Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бодит буюу боломжит мэдээллүүдийг тодорхойлох, түүнийг судлан шинжилгээ хийх.**
- **Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах, ингэхдээ сонгуулийн кампанит ажлын зардал болон сонгогдох магадлалын хамаарлыг тодорхойлох.**

Дээрх хоёр зорилтын хүрээнд судалгаанд ашиглах ёстой мэдээллийг олохын тулд Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ), Үндэсний Аудитын газар (ҮАГ), Улс төрийн намуудын сайт зэрэг боломжит мэдээллийн платформууд дээр хайлт хийж

[22] Ариунаа.Ц. Парламентын судалгааны хүрээлэн

эхэлсэн. СЕХ-ны сайт дээр “1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн” гэсэн файл байгаа боловч судлаачдад нээлттэй, боловсруулан анализ хийх боломжтой өгөгдөл биш, .pdf өргөтгөлтэй байсан нь дата мэдээлэл боловсруулах ажилд нөлөөлж байсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах, ингэхдээ сонгуулийн кампанит ажлын зардал болон сонгогдох магадлалын хамаарлыг тодорхойлох зорилтын хүрээнд харьцуулагдах ёстой зардлын тайлангуудаас зөвхөн 2009, 2013, 2017 оны зардлын тайлан .pdf өргөтгөлтэй олдсон (СЕХ-ны сайт дээр зөвхөн 2013 оны зардлын тайлан байв). Бусад оны тайлан олдоогүй. Эндээс улс төрийн нам, нэр дэвшигчдийн санхүүгийн тайлан иргэд сонгогчдод нээлттэй, ил тод байх ёстой гэсэн зарчим, хуулийн заалт үйлчлэхгүй байгаа нь энэхүү судалгааны хүрээнд ажиглагдлаа.

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ОРОЛЦОО

**Дүгнэлт 1:** Сонгогчдын оролцоо жилээс жилд буурсаар байна. Энэхүү хугацаанд орон нутаг дахь сонгогчдын оролцоо 34.8 хувиар, Улаанбаатар хотын сонгогчдын оролцоо 27.4 хувиар буурчээ (Зураг 1)

Зураг 1. Сонгогчдын оролцоо: Орон нутаг ба Улаанбаатар хот




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

**Дүгнэлт 2:** Дундговь аймагт сонгуулийн ирц хамгийн өндөр буюу нийт сонгогчдын 73.3 хувь нь Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон бол Дорноговь аймагт хамгийн бага буюу тус хэмжээ 67.1 хувь байна (Хүснэгт 1).

Бүс нутгийн байршлаас үл хамааран сонгуулийн оролцооны эрэмбэ тодорхойлогдож байна. Тодруулбал, сонгогчдын оролцоо хамгийн өндөр таван аймаг нь Төв, Хангай, Баруун бүс, Улаанбаатар хотод хамаарч байна.

Хүснэгт 3. Сонгогчдын оролцоо, аймгуудын эрэмбэ (2000 оноос хойш)

| **Аймаг** | **Оролцооны хувь** | **Эрэмбэ** | **Аймаг** | **Оролцооны хувь** | **Эрэмбэ** |
|---|---|---|---|---|---|
| Дундговь | 73.3% | 1 | Говьсүмбэр | 70.2% | 12 |
| Өвөрхангай | 72.8% | 2 | Дорнод | 70.0% | 13 |
| Говь-Алтай | 72.6% | 3 | Баян-Өлгий | 69.8% | 14 |
| Улаанбаатар | 72.4% | 4 | Архангай | 69.8% | 15 |
| Булган | 72.0% | 5 | Орхон | 69.7% | 16 |
| Баянхонгор | 72.0% | 6 | Завхан | 69.6% | 17 |
| Ховд | 71.5% | 7 | Төв | 69.3% | 18 |
| Сүхбаатар | 71.4% | 8 | Дархан-Уул | 69.3% | 19 |
| Өмнөговь | 71.1% | 9 | Хэнтий | 68.9% | 20 |
| Сэлэнгэ | 71.1% | 10 | Увс | 68.8% | 21 |
| Хөвсгөл | 70.2% | 11 | Дорноговь | 67.1% | 22 |
| Нийт | 71.2% | | | | |

*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

Тоон мэдээллээс дүгнэхэд нийт аймгийн 25 хувь нь 69.6 хүртэл хувийн ирцтэй, 50 хувь нь 70.2 хүртэл хувийн ирцтэй, 75 хувь нь 71.8 хувийн ирцтэй байжээ. Энэхүү ангиллаар дөрвөн хэсэгт хуваан сонгогчдын оролцоог аймгуудаар харууллаа (Зураг 2). Үүнд хамгийн оролцоо сайтай аймгуудыг тод хөх өнгөөр, оролцоо багасах тусам бүдэг хөх өнгөөр тэмдэглэсэн болно.

Зураг 2. Сонгогчдын оролцоо: Аймгаар



*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

**Дүгнэлт 3:** Сонгогчдын оролцоонд тухайн орон нутгийн үйлдвэрлэл (бодит ДНБ), ажил эрхлэлтийн түвшин (нийт хүн амд эзлэх ажилчдын тоо), эрүүл мэндийн үйлчилгээ (эмчийн хүрэлцээ), дахин сонгууль эсэхээс тус тус хамаардаг байна (Хүснэгт 2).

Ерөнхийлөгчийн сонгуулийн 2001, 2005, 2009, 2013, 2017 (I, II) оны үр дүнгүүдийг ашиглан сонгогчдын оролцоонд нөлөөлж буй макро хувьсагчдын талаар бага хэмжээний үнэлгээ хийж үзлээ. Нийт 21 аймаг болон Улаанбаатар хотын, зургаан удаагийн сонгууль буюу 132 өгөгдлийг ашигласан бөгөөд хоёр төрлөөр өгөгдлийг өөрчилж, үнэлсэн (Хавсралтаас дэлгэрүүлэн харах боломжтой). Ингэхдээ:

1. Сонгогч дөрвөн жилийн хугацаанд тухайн хувьсагчийн дундаж утгаас хамааран сонгуульд оролцох, эсэхээ шийддэг тохиолдол,
2. Сонгогч зөвхөн сонгуулийн өмнө буюу манай өгөгдлийн хувьд өмнөх жилийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамааран сонгуульд оролцох, эсэхээ шийддэг тохиолдол хэмээн хоёр төрлийн өгөгдөл үүсгэн үнэлгээг хийв.

Хүснэгт 4. Сонгогчдын оролцоонд нөлөөлж буй макро эдийн засгийн үзүүлэлтүүд

| Нөлөөлөгч хүчин зүйлс | 4 жилийн дундаж | Сонгуулийн өмнөх жил |
|---|---|---|
| **Нэг хүнд ногдох БДНБ** | - | Нөлөөгүй |
| **ЕБС-д суралцагчдын тоо** | Нөлөөгүй | Нөлөөгүй |
| **Ажилчдын нийт хүн амд эзлэх %** | - | - |
| **Эмчийн хүрэлцээ** | - | - |
| **Дахин сонгууль, эсэх** | - | - |

*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Үнэлгээнд панел хамгийн бага квадратын арга (ХБКА), тогтмол нөлөөлөл, эсвэл хувьсах нөлөөлөл (fixed or random effect model)-ийн арга зүйг ашиглалаа. Ерөнхий үр дүнгүүд арга зүйгээс үл хамааран хоорондоо нийцтэй байсан. Тухайн сонгогч сонгуульд оролцох, эсэх шийдвэрээ гаргахдаа оршин суугаа газрын орлого, ажилгүйдэл, эрүүл мэндийн салбарын байдал зэрэг хувьсагчдыг харгалзах бөгөөд тухайн сонгогчдын боловсролын түвшин бас нөлөөлнө хэмээн таамаглалаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Үнэлгээний үр дүнд:

- Тухайн газрын бодит орлого, үйлдвэрлэл өндөр, ажилгүйдэл бага, эрүүл мэндийн салбар сайн, эмчийн хүрэлцээ их байх тусам иргэн сонгуульд оролцох магадлал буурна.
- Дахин сонгууль зохион байгуулж буй тохиолдолд мөн иргэний оролцоо буурах юм.

**Дүгнэлт 4:** Эхэн үеийн Ерөнхийлөгчийн сонгуульд эрх барьж буй нам болон Ерөнхийлөгчийн нам ялгаатай тогтож байсан боловч сүүлийн жилүүдэд өөрчлөгджээ.

Хүснэгт 5. Ерөнхийлөгчийн сонгууль ба УИХ-ын сонгууль

| | **УИХ** | **Ерөнхийлөгч** |
|---|---|---|
| 1993 | | |
| 1997 | | |
| 2001 | | |
| 2005 | | |
| 2009 | | |
| 2013 | | |
| 2017 | | |

Энэхүү хүснэгтэд Монгол Ардын Нам ялсан үеийг улаан өнгөөр, Ардчилсан Нам ялсан үеийг хөх өнгөөр тус тус тэмдэглэлээ.

Зураг 3. Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн: Нэр дэвшигчдээр




*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

UIH.MN

**Дүгнэлт 5:** Хүчингүй болон цагаан саналын нийт саналд эзлэх хувь хэмжээ жилээс жилд буурч байгаа болович дахин сонгуулийн үеэр огцом өсөж, найман хувьд хүрсэн байна. Нийт саналын 97 хувь нь хүчинтэй санал байсан бол гурван хувь нь хүчингүй санал байжээ. Орон нутаг, эсвэл Улаанбаатар хотын сонгуулиас үл хамааран хүчингүй эсвэл цагаан саналын хувь хэмжээ ойролцоо байсаар ирсэн (Зураг 4).

Зураг 4. Хүчингүй, эсвэл цагаан саналын нийт саналд эзлэх хувь




*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

**Дүгнэлт 6:** Ерөнхийлөгчийн сонгуулийн жил болон тухайн жилийн өмнөх жилүүдэд орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгддэг байна. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх жил нь УИХ-ын сонгуультай давхацдаг бөгөөд хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх бусад олон хүчин зүйл байдгийг онцлох нь зүйтэй.

Зураг 5. Хүн амын цэвэр шилжилт




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

**Дүгнэлт 7:** Нэр дэвшигчдийн зурагтын сувгаар гарсан хугацаа болон санал хооронд эерэг хамааралтай байна.

Глоб интернэшнл төв 2009 болон 2017 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны хамгийн идэвхтэй хоёр долоо хоногийн хугацаанд хэвлэл мэдээллийн мониторинг хийжээ. Судалгаанд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг таван сувгийг хамруулсан бөгөөд сонгуулийн сурталчилгааны хугацаа, нэр дэвшигчдийн талаар мэдээлэл, сонгогчдын боловсрол зэргийг судалсан байна (Зураг 6).

Зураг 6. Хэвлэлийн мониторинг: 2009 ба 2017 оны дүн




*Эх сурвалж: Глоб интернэшнл*

Зураг 7. Санал ба хэвлэлд цацагдсан хугацаа хоорондын хамаарал




*Эх сурвалж: Глоб интернэшнл*

Нэр дэвшигчдийн талаар мэдээлсэн хугацаа болон тухайн нэр дэвшигчийн авсан санал хоорондох хамаарлыг цэгэн түгэлтийн диаграммаар харуулав (Зураг 7). Ерөнхий хамаарал эерэг бөгөөд тус хувьсагчид хоорондын корреляцийн коэффициент 0.67 гарсан юм. Өөрөөр хэлбэл, тухайн нэр дэвшигч зурагтаар их гарах тусам мэдээний утгаас үл хамааран сонгогдох магадлал их байгааг харж болно. Гэхдээ энэхүү тооцоолол нь зөвхөн 2009, 2013 болон 2017 оны сонгуульд үндэслэснийг анхаарах шаардлагатай.

UHLMN
СУДАЛГААНЫ САН

**Дүгнэлт 8:** Нэр дэвшигчдийн сонгуулийн ажлын орлогын дийлэнх хувийг иргэдийн хандив эзэлдэг бол зардлын дийлэнх хувь нь нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг таниулахад зарцуулагдаж байна.

Нэр дэвшигчдийн орлого нь хуулийн этгээд, иргэд, намаас өгсөн хандив болон нэр дэвшигчийн хувийн хөрөнгөөс бүрддэг. Гэхдээ бидэнд байгаа тоон мэдээллээс дүгнэхэд нэр дэвшигчид өөрийн хөрөнгөөс сонгуулийн компанит ажилд зарцуулах явдал гараагүй юм. Харин орлогын 50-иас дээш хувь нь иргэдийн хандиваас, үлдсэн нь хуулийн этгээд болон намын хандиваас бүрдсэн байна (Зураг 8).

Зураг 8. Нэр дэвшигчдийн орлогын задаргаа: 2009-2017 он




*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 9. Нэр дэвшигчдийн зардлын задаргаа: Нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал ба бусад зардлын харьцаа (2009 ба 2017 он)




| | | | | |
|---|---|---|---|---|
| Н.Энхбаяр (МАХН) | Ц.Элбэгдорж/АН | М.Энхболд/МАН | Х.Баттулга/АН | С.Ганбаатар/МАХН |

*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

*Энд: Нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардлын нийт зардалд эзлэх хувийг тодруулав.*

Нэр дэвшигчийн зардлыг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал, уулзалт, хурал зохион байгуулах зардал, шуудан, шатахуун, цалин хөлс зэрэг бусад зардал бүрдүүлжээ. Үүнээс нэр дэвшигчийг сурталчлах, мөрийн хөтөлбөрийг таниулах зардал нийт зардлын дийлэнх хувийг эзэлж байгаа ч тухайн нэр дэвшигчийн онцлогоос хамааран зардлын бүтэц харилцан адилгүй байв (Зураг 9).

**Дүгнэлт 9:** Нэр дэвшигчдийн зардал болон санал хооронд сул хэмжээний эерэг хамаарал ажиглагдлаа.

Нэр дэвшигчийн сонгуулийн зардал болон авсан санал хоорондын хамаарлыг зураг 10б-д харуулав. Нийт 2009-2017 оны гурван удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн тоон мэдээллээс дүгнэхэд тухайн хоёр хувьсагч хооронд эерэг хамаарал[23] ажиглагдав. Мөн тухайн нэр дэвшигчийн санал болон тодорхой бүлэг зардал хооронд хүчтэй хамаарал ажиглагдаагүй. Тухайлбал, нэр дэвшигчийг сурталчлах, мөрийн хөтөлбөрийг тайлбарлах зардал болон нэр дэвшигчийн авсан санал хооронд маш бага хэмжээний сөрөг хамаарал байсан.

Зураг 10. Нэр дэвшигчдийн зардал ба авсан санал хоорондын хамаарал

а. Нэр дэвшигчийг сурталчлах зардал ба санал хоорондын хамаарал

б. Нэр дэвшигчийн сонгуулийн зардал ба санал хоорондын хамаарал




*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Дүгнэлт 10:** Нэр дэвшигчийн авах саналд аль намаас нэр дэвшсэн, эсэх хамгийн гол нөлөөлдөг.

Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдсан 1993-2017 оны хооронд нийт 20 нэр дэвшигч тус сонгуульд өрсөлджээ. Улсын хэмжээнд нэр дэвшигчдийн авсан саналд нөлөөлж буй хүчин зүйлсийг энгийн хамгийн бага квадратын аргаар үнэлэв. Ингэхэд аль намд харьяалагдаж буй нь нэр дэвшигчдийн авч буй саналд хамгийн хүчтэй нөлөөлж

[23] Корреляцийн коэффициент 0.60 байв.

байсан. Өөрөөр хэлбэл, МАН-ын нэр дэвшигч тохиолдолд авах саналын хэмжээ дунджаар 17.4 хувиар нэмэгдэхээр байна. Харин нас, хүйс, эдийн засгийн мэргэжилтэй, эсэх хувьсагчид нь 95 хувийн магадлалтай статистикийн хувьд ач холбогдолгүй байв.

Хүснэгт 6. Нэр дэвшигчийн авсан санал ба хувийн мэдээлэл хоорондын хамаарал

| Хувьсагч | Хамаарал | Ач холбогдолтой эсэх |
|---|---|---|
| Нас | Нэр дэвшигчийн нас нэгээр нэмэгдэхэд авах санал 1.4 хувиар буурна. | Ач холбогдолгүй. |
| Нам | МАН-ын гишүүн бол авах санал 17.4 хувиар нэмэгдэнэ. | Ач холбогдолтой. |
| Хүйс | Эмэгтэй бол авах санал 12.2 хувиар буурна. | Ач холбогдолгүй. |
| Мэргэжил | Эдийн засгийн мэргэжилтэй бол авах санал 4.2 хувиар буурна. | Ач холбогдолгүй. |

*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

**Дүгнэлт 11:** Сонгогчдын ирц тогтвортой буурч байгаагаас үүдэн ялсан нэр дэвшигчийн нийт сонгогчоос авсан саналын хувь буурсаар байна.

Ерөнхийлөгчийн анхны сонгууль буюу 1993 онд сонгуулийн ирц 92.7 хувьтай байснаар нийт сонгогчдын 54 хувь нь Ерөнхийлөгчөө сонгож байв. Харин 2017 онд сонгуулийн ирц 60.7 хувь болж, 32 хувиар буурснаар нийт сонгогчдын 31 хувь Ерөнхийлөгчийг сонгосон байна. Ерөнхийлөгч нь дийлэнх иргэний саналаар сонгогдох ёстой боловч сонгуулийн оролцоо, идэвх сул байгаагаас ялсан нэр дэвшигчийн нийт сонгогчдоос авсан саналын хувь буурч, иргэдийн саналыг төлөөлөх чадвар буурсаар байгаа юм.

Зураг 11. Сонгуулийн ирц ба ялсан нэр дэвшигчийн авсан санал




*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Түүнчлэн сонгуулийн сурталчилгааны хоног болон сонгуулийн ирц хооронд сул хэмжээний эерэг хамаарал ажиглагдсаныг онцлох нь зүйтэй юм.

**Дүгнэлт 12:** Мөрийн хөтөлбөр нь нам, нэр дэвшигчийн онцлогоос хамааран харилцан адилгүй байна. Хүснэгт 5-д АН болон МАН (МАХН)-ын хоёр, хоёр удаагийн ялалт байгуулсан сонгуулийг авч үзлээ. Сонирхолтой нь, АН-ын сонгуулийн уриа, үндсэн агуулга МАН-тай харьцуулахад товч байв.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 7. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн харьцуулалт

| Он | Нэр дэвшигч | Нам | Уриа | Мөрийн хөтөлбөрийн үндсэн агуулга | Ялсан, эсэх |
|---|---|---|---|---|---|
| 2001 | Н.Багабанди | МАХН | Төрийн хэрэг иргэдээсээ Иргэний амьдрал төрөөсөө | Төр иргэдийн хоорондох итгэлцлийг бэхжүүлж, иргэддээ үйлчилдэг, иргэд нь төрийнхөө төлөө зүтгэдэг зарчмыг хэрэгжүүлэх. Иргэн бүр бүтээлчээр хөдөлмөрлөж, элбэг хангалуун, амгалан тайван амьдрах нөхцөлийг төрөөс бүрдүүлнэ. | |
| | Р.Гончигдорж | АН | Тэнцвэртэй төр Тогтвортой хөгжил | Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн өндөр хариуцлагын түвшинд иргэддээ ил тод байдлаар хэрэгжүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлууд дотроос холбогдох асуудлуудыг шийдвэрлэнэ. | |
| | Л.Дашням | Иргэний зориг нам | Эх орон Эв нэгдэл | Монгол оронд хүмүүнлэг амьдрал, чадварлаг төр, хүчирхэг эдийн засаг, эвсэг харилцааг хөгжүүлэхийн төлөө ардчилал, эрх ашгийн эрэмбэ, андын зөвшилцлийн зарчмыг ямагт эрхэмлэнэ. | |
| 2005 | Н.Энхбаяр | МАХН | Хөгжлийн төлөө бодлого Хүний төлөө зүтгэл | Ардчилсан засаглалыг бэхжүүлж, соёлтой бизнес, хөгжлийн суурь бүтээн байгуулалтыг дэмжинэ. | |
| | М.Энхсайхан | АН | Авлигачдыг цээрлүүлнэ | Авлигал, хээл хахуультай тууштай тэмцэж, төрийг авлигачдаас цэвэрлэх, тэдэнд хуулийн дээд цээрлэл үзүүлнэ. | |
| | Б.Эрдэнэбат | Эх орон нам | Эрх чөлөөт иргэн Эрх зүйт төр | Ард түмнийхээ эрх ашиг, үндэсний эв нэгдэл, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг дээдлэн, иргэдийн эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, эрх зүйт төрийг хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. | |
| | Б.Жаргалсайхан | БНН | - | Улс орны хөгжил дэвшил, ард түмний аж амьдралыг сайжруулж, улс төрийн системийн хямралыг арилгана. Нийгмийн амьдралын бүх хүрээнд бүтээн байгуулалтын эрс шинэчлэл хийнэ. | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2009 | Н.Энхбаяр | МАХН | Эвийг хүч дагана Хүчийг хөгжил дагана | Хариуцлагатай шударга төр, иргэншсэн эвсэг нийгэм, өсөлттэй, өгөөжтэй эдийн засгийг бүрдүүлнэ. |
| | Ц.Элбэгдорж | АН | Шударга байцгаая | Шударга ёсны асуудал, орон нутгийн хөгжил, ард түмний төлөө, байгаль орчны хамгаалал, гадаад бодлогод төвлөрнө. |
| 2017 | Х.Баттулга | АН | Монгол ялна. | Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн байдал, халдашгүй дархан байдал, ардчилал, эрх чөлөө, хүний эрх, шударга ёсыг дээдлэн үндэсний язгуур эрх ашгийг тууштай хамгаалах бодлогыг дэмжинэ. |
| | М.Энхболд | МАН | "Эвтэй Монгол, Ээлтэй төр" | "Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлж, төрийн бодлого иргэдийн саналд тулгуурладаг, ардчилсан засаглалыг бэхжүүлэх төрийн бодлогыг бий болгох" |
| | С.Ганбаатар | МАХН | Монголоо сонгоё | Төр засгийн хариуцлагыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг буруулж, алга болгоно. |

*Эх сурвалж: Мэдээллийн сайтууд, Сонгуулийн ерөнхий хороо*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

- Парламентын хаант болон парламентын Бүгд найрамдах улсад хууль санаачлах эрх бүхий субъект харилцан адилгүй байна. Эдгээр 19 орноос:
  - Төрийн тэргүүн (Ерөнхийлөгч, Хаан) нь хууль санаачлах эрхгүй улс - 14 (БНХАУ, Испани, Итали, Их Британи, Киргиз, Македон, Серби, Сингапур, Словак, Турк, Финланд, Хорват, Монтенегро, Япон);
  - Ерөнхийлөгч зөвхөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачлах эрхтэй улс - хоёр (Болгар, Эстони);
  - Ерөнхийлөгч хууль санаачлах бүрэн эрхтэй улс - дөрөв (Латви, Исланд, Унгар, Монгол).
- Ерөнхийлөгч, парламентыг нийтээрээ сонгодог Монгол Улстай ижил төстэй сонгуулийн тогтолцоо бүхий 11 улс (Болгар, Исланд, Киргиз, Македон, Сингапур, Серби, Словак, Турк, Финланд, Хорват, Монтенегро) байна.
- Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бие даан хэрэгжүүлдэг 20 бүрэн эрх байгаагаас "Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх" Латви, Унгар, Исланд, Монгол Улсад байх бөгөөд бусад 10 орны Ерөнхийлөгч нь хууль санаачлах эрхгүй. Харин "уучлал үзүүлэх эрх" нь 11 орны Ерөнхийлөгчид олгогдсоноороо нийтлэг ажээ. Бусад 11 бүрэн эрхийн хувьд улс орон бүрд харилцан адилгүй байна.
- Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бусад субъекттэй хамтран хэрэгжүүлдэг эрхийг дээрх орнуудаас Ерөнхийлөгч, парламентыг (парламентын нэг танхимтай) бүх нийтээр сонгодог Монгол Улстай ижил төстэй сонгуулийн тогтолцоо бүхий 11 улс байна. Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн хамтран хэрэгжүүлдэг найман эрх байгаагаас "Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрх" эдгээр 11 улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна. Бусад долоон эрхийн хувьд улс орон бүрд харилцан адилгүй байна.
- Сонгогчдын оролцоо жил ирэх тусам буурч байна.
- Дундговь аймагт сонгуулийн ирц хамгийн өндөр байгаа бол Дорноговь аймагт хамгийн бага байна.
- Тухайн аймаг, хотын бодит орлого, үйлдвэрлэл өндөр, ажилгүйдэл бага, эрүүл мэндийн салбар сайн, эмчийн хүрэлцээ их байх тусам иргэн сонгуульд оролцох магадлал буурна. Мөн дахин сонгууль зохион байгуулж буй тохиолдолд иргэний оролцоо буурдаг байна.
- Нэр дэвшигчдийн зурагтын сувгаар гарсан хугацаа, сонгуульт ажлын зардал нь авч буй саналын хэмжээнд эергээр нөлөөлж байна.
- Нэр дэвшигчийн авах саналд нас, хүйс, мэргэжлээс илүүтэй аль намаас нэр дэвшиж байгаа, эсэх хамгийн гол нөлөөлдөг. Тодруулбал, МАН (МАХН)-аас дэвшиж буй нөхцөлд авах саналын хэмжээ 17.4 хувиар нэмэгдэж байна.
- Сонгогчдын ирц тогтвортой буурч байгаагаас үүдэн ялсан нэр дэвшигчийн нийт сонгогчоос авсан саналын хувь буурсаар байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**САНАЛ:**

Сонгуулийн оролцоо, үүнд нөлөөлж буй хүчин зүйлс, бүх төрлийн сонгуулийн нөхцөл байдал, нэр дэвшигчдийн авч буй санал, үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар хийгдсэн судалгаа Монгол Улсад дутмаг байна. Энэ төрлийн судалгааг хийж, цаашид хөгжүүлэх нь сонгуулийн бодлогын шийдвэр гаргалтад чухал ач холбогдолтой билээ. Энэхүү судалгааг хийх явцад өгөгдөл тун дутмаг байгаа нь зарим төрлийн тооцоо, шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байна. Монгол Улсад 1993 оноос хойш нийт найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдсан буюу өгөгдлийн урт харьцангуй богино юм. Иймд өгөгдлийг аймаг, сум, хороодоор илүү дэлгэрүүлэн мэдээлэх нь судалгаа, шинжилгээний чанарыг сайжруулах ач холбогдолтой байна. Тухайлбал:

- Сонгогчдын нас, хүйс, боловсрол, санал өгсөн цаг (үдээс өмнө эсвэл хойш)-ийн мэдээллийг байршлаар нь нээлттэй мэдээлэх
- Сонгуулийн зардал болон орлогын мониторингийг тогтмол хийх, мэдээллийг бүс нутгаар нээлттэй мэдээлэх
- Хэвлэл мэдээллийн мониторингийг тогтмол хийх
- Сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг судлаачдад нээлттэй өгөгдөл байдлаар мэдээлэх
- Сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг СЕХ-ны болон бусад сайт дээр тогтмол байлгах, арилгахгүй байх.
- Цаашид Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал, сонгуулийн тогтолцоо, сонгуульд оролцож буй намуудын өрсөлдөөн, сонгуулийн кампанит ажлын онцлог, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн харьцуулалт болон хэрэгжилт, сонгогчдын үйл байдал, хандлага зэргийг цаашид гүнзгийрүүлэн судалж, тогтмол харьцуулан анализ хийх.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ХАВСРАЛТ 1**

**Парламентын засаглалтай орны Төрийн тэргүүний бүрэн эрх**

| № | Улсын нэр | Эрх зүйн зохицуулалт |
|---|---|---|
| 1 | БНХАУ | Үндсэн хууль:<br>80.БНХАУ-ын Дарга нь Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (Парламент), Байнгын хорооны шийдвэрийн дагуу хуулийг нийтлэх, Ерөнхий сайд, Ерөнхий сайдын орлогч, Төрийн зөвлөл (Засгийн газар)-ийн гишүүд, сайд нар, Ерөнхий аудитор, Төрийн зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн даргыг томилж, чөлөөлөх, төрийн одон медаль, цол олгох, тусгай уучлал үзүүлэх, онц болон дайны байдал зарлах, дайчилгаа явуулах эрхтэй.<br>81.БНХАУ-ын Дарга нь БНХАУ-ын нэрийн өмнөөс улсын үйл хэргийг явуулж, гадаадын дипломат төлөөлөгчдийг хүлээн авах, БХАТИХ-ын Байнгын хорооноос гаргасан шийдвэрийг үндэслэн гадаадад суух бүрэн эрхт төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах, гадаад улстай байгуулсан гэрээ, чухал хэлэлцээрийг зөвшөөрөх, хүчингүй болгох эрхтэй.<br>82.БНХАУ-ын дэд дарга нь БНХАУ-ын Даргын ажилд туслалцаа үзүүлж ажиллана. БНХАУ-ын Даргын эрх олгосноор түүний зарим эрх, үүргийг хэрэгжүүлнэ.<br>83.БНХАУ-ын Дарга, дэд дарга нь дараагийн БХАТИХ-аас шинэ Дарга, дэд дарга сонгогдтол өөрсдийн албан үүргээ хэрэгжүүлнэ.<br>84.БНХАУ-ын Даргын албын ор гарсан бол дэд дарга түүний албан үүргийг залгамжилна. Хэрэв дэд даргын ор гарсан бол БХАТИХ-аас шинэ дэд дарга нөхөн сонгоно. Хэрэв Дарга, дэд даргын аль алиных нь ор гарсан бол БХАТИХ шинэ Дарга нарыг нөхөн сонгоно. Дарга нарыг нөхөн сонгох хүртэл БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Улсын Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэнэ. |
| 2 | Болгар | Үндсэн хууль:<br>98.Ерөнхийлөгч дараах бүрэн эрхтэй:<br>1.Үндэсний Ассамблей, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийг товлон зарлах, хэрэв Үндэсний Ассамблей бүх ард түмний санал асуулга явуулах шийдвэр гаргасан бол санал асуулга явуулах өдрийг товлон зарлах;<br>2.Ард түмэндээ болон Үндэсний Ассамблейд хандан үг хэлэх; |

UIH.MN
ЧУУЛГАНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 3.Хуульд заасан тодорхой нөхцөлд олон улсын гэрээ байгуулах;<br>4.Хууль ёсчлох;<br>5.Сайд нарын Зөвлөлийн санал болгосноор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, тэдгээрийн төвийг өөрчлөх;<br>6.Сайд нарын зөвлөлийн санал болгосноор бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн болон олон улсын байгууллагад ажиллах Болгар Улсын төлөөлөгчийг томилох, чөлөөлөх, Болгар Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;<br>7.Хуульд заасны дагуу төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх;<br>8.Одон, медалиар шагнах;<br>9.Болгар Улсын харьяат болгох, харьяаллыг сэргээх, харьяатаас чөлөөлөх, гаргах;<br>10.Орогнох эрх олгох;<br>11.Уучлал үзүүлэх;<br>12.Найдваргүй өрийг цуцлах;<br>13.Архитектурын дурсгалт газар, суурин газрыг үндэсний зэрэглэлтэй болгох;<br>14.Өөрийн бүрэн эрхэд хамаарах үндсэн асуудлаар Үндэсний Ассамблейд мэдээлэл хийх.<br>99.1.Парламентын бүлгүүдтэй зөвшилцсөний дараа Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейд хамгийн олон суудал авсан бүлгээс санал болгосон Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгнө.<br>99.5.Хэрэв Засгийн газрыг бүрдүүлэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй бол Ерөнхийлөгч түр Засгийн газрыг томилох ба Үндэсний Ассамблейг тарааж, шинэ сонгуулийг Үндсэн хуулийн 61.3-т заасан хугацаанд товлон зарлана. Үндэсний Ассамблейг тараасан тухай Ерөнхийлөгчийн зарлигт шинэ сонгууль явуулах өдрийг товлон зарлана.<br>99.6.Энэ зүйлд заасан Засгийн газрыг бүрдүүлэх журмыг Үндсэн хуулийн 111.1-т заасан нөхцөл байдалд хэрэглэнэ.<br>99.7.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусах гурав сарын хугацаанд энэ зүйлийн 5 болон 6 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон бол Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейг тараахгүй. Хэрэв энэ хугацаанд парламент нь Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч түр Засгийн газрыг томилно.<br>100.1.Ерөнхийлөгч Болгар Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>100.2.Сайд нарын зөвлөлийн санал болгосноор зэвсэгт хүчний дээд командлалын бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, цэргийн дээд цолыг олгоно. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 100.3.Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааныг хуульд заасны дагуу удирдан явуулна.<br>100.4.Ерөнхийлөгч хуульд заасны дагуу Сайд нарын зөвлөлийн санал болгосноор бүх нийтийн, эсхүл хэсэгчилсэн дайчилгааг зарлана.<br>100.5.Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейн чуулган хуралдаагүй, эсхүл нэн даруй хуралдуулах боломжгүй үед Болгар Улсад зэвсэглэн халдсан, эсхүл олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу яаралтай арга хэмжээ авах шаардлагатай болсон бол дайны, эсхүл онц байдал зарлана. Үүний дараа Үндэсний Ассамблей нэн даруй хуралдаж Ерөнхийлөгчийн шийдвэрийг баталгаажуулна.<br>102.1.Ерөнхийлөгч өөрийн онцгой эрхийн хүрээнд зарлиг гаргах, үг хэлэх, мэдэгдэл хийх эрхтэй.<br>102.2.Ерөнхийлөгчийн зарлигт Ерөнхий сайд, эсхүл холбогдох салбарын сайд баталгаажих гарын үсэг зурна.<br>102.3.Дараах зарлигт баталгаажих гарын үсэг зурахгүй:<br>1.Түр Засгийн газрыг томилох тухай;<br>2.Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгөх тухай;<br>3.Үндэсний Ассамблейг тараах тухай;<br>4.Үндэсний Ассамблейд хуулийн төсөл буцаах;<br>5.Ерөнхийлөгчийн албаны бүтэц, үйл ажиллагааны журмыг тогтоох ба албан хаагчдыг томилох;<br>6.сонгууль, эсхүл ард түмний санал асуулгын хуваарийг гаргах;<br>7.Хууль тунхаглан зарлах.<br>104.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн 7, 9, 10, 11, 98 дугаар зүйлд заасан онцгой эрхийг Дэд ерөнхийлөгчид шилжүүлэх эрхтэй. |
| 3 | Исланд | Үндсэн хууль:<br>15.Ерөнхийлөгч сайд нарыг томилж, чөлөөлнө. Сайдын тоо болон эрх, үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.<br>21.Ерөнхийлөгч бусад улс оронтой гэрээ байгуулна. Ерөнхийлөгч улс орны хараат байдал, газар нутаг болон эзэмшлийн далай, эсхүл улс орны тогтолцоонд өөрчлөлт оруулах утга агуулсан гэрээг парламентаас өөрөөр заагаагүй бол байгуулах эрхгүй байна.<br>22.Ерөнхийлөгч парламентын сонгууль явагдсанаас хойш 10 долоо хоногоос хэтрэлгүй парламентын анхдугаар чуулганыг товлон зарлана.<br>23.Ерөнхийлөгч парламентыг жилд нэг удаа хоёр долоо хоногоос ихгүй хугацаанд завсарлуулах эрхтэй байна. Ерөнхийлөгч өөрийн хүсэлтээр мөн парламентын гишүүдийн олонхын шаардсанаар ээлжит бус чуулганыг зарлана. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 25.Ерөнхийлөгч хуулийн төсөл болон бусад шийдвэрийн төслийг парламентад өргөн барих эрхтэй байна.<br>26.Парламентаар батлагдсан хуулийг хоёр долоо хоногоос хэтрэлгүй Ерөнхийлөгчид зарлан тунхаглуулахаар өргөн барих бөгөөд Ерөнхийлөгч зарлан тунхагласнаар хууль хүчин төгөлдөр болно. Хуулийг буцаасан тохиолдолд гишүүд нууц санал хураалтаар батална. Батлагдаагүй бол хуулийг хүчингүйд тооцно.<br>29.Ерөнхийлөгч өршөөл болон уучлал үзүүлнэ. |
| 4 | Испани | Үндсэн хууль:<br>62.Эзэн хаан дараах бүрэн эрхтэй:<br>1.Хуульд хориг тавих, ёсчлох;<br>2.Их Хурал (парламент)-ыг зарлан хуралдуулах, Их Хурлыг тараах, Үндсэн хуульд заасан хугацаанд сонгуулийг товлон зарлах;<br>3.Үндсэн хуульд заасны дагуу ард нийтийн санал асуулгыг товлон зарлах;<br>4.Засгийн газрын тэргүүнд нэр дэвшигчийг санал болгох, томилох, эсхүл Үндсэн хуульд заасны дагуу албан тушаалаас нь чөлөөлөх;<br>5.Засгийн газрын тэргүүний санал болгосноор Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх;<br>6.Цэргийн цол, иргэний албан тушаалын зэрэг дэв, хүндэт шагналыг хуульд заасан журмын дагуу олгохоор Сайд нарын зөвлөлийн баталсны дагуу зарлиг гаргах;<br>7.Төрийн хэргээр мэдээлэлтэй байх, энэ зорилгоор Засгийн газрын тэргүүний хүсэлтээр, Сайд нарын зөвлөлийн хуралд хэдийд ч даргалах эрхтэйгээр оролцох;<br>8.Зэвсэгт хүчний дээд удирдлагыг хэрэгжүүлэх;<br>9.Уучлал үзүүлэх эрхтэй ба хуульд заасны дагуу ерөнхий өршөөл үзүүлэх эрх олгох;<br>10.Эзэн хааны академийн дээд ивээл үзүүлэх.<br>63.1.Эзэн хаан гадаад улсын элчин сайдууд болон дипломат төлөөлөгчдийг хүлээн авч итгэмжилнэ. Испани дахь гадаадын төлөөлөгчдийг мөн итгэмжилнэ.<br>63.2.Эзэн хаан Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг дэмжиж байгаа, эсэхээ илэрхийлнэ.<br>63.3.Эзэн хаан Их Хурлын зөвшөөрсний дараа дайны болон энх тайвны байдал зарлана. |
| 5 | Итали | Үндсэн хууль: |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 87.Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийн илэрхийлэгч байна. Ерөнхийлөгч парламентад үг хэлж болно.<br>Ерөнхийлөгч дараах бүрэн эрхтэй:<br>-Засгийн газрын санаачилсан хуулийн төслийг парламентад танилцуулах;<br>-Хууль, хуулийн хүчин чадалтай зарлиг, журмыг соёрхон батлах;<br>-Үндсэн хуульд заасан тохиолдолд ард нийтийн санал асуулгыг товлон зарлах;<br>-Хуульд заасан тохиолдолд төрийн албан хаагчдыг томилох;<br>-Дипломат төлөөлөгчдийг итгэмжлэх, хүлээн авах, шаардлагатай бол парламентаас зөвшөөрсөн тохиолдолд олон улсын гэрээг соёрхон батлах;<br>-Өршөөл үзүүлэх, ял шийтгэлийг хөнгөрүүлэх.<br>Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба хуулиар тогтоосон Батлан хамгаалах дээд зөвлөлийг тэргүүлж, парламентын зөвшөөрснөөр дайны байдал зарлана.<br>Ерөнхийлөгч Шүүхийн дээд зөвлөлийг тэргүүлнэ.<br>Ерөнхийлөгч Бүгд найрамдах улсын төрийн шагнал, өргөмжлөл, цол олгоно.<br>88.Парламентыг даргалж буй албан тушаалтантай зөвшилцөн парламентын аль нэг танхимыг, эсхүл хоёр танхимыг тарааж болно. Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрх дуусгавар болохоос зургаан сарын өмнө, эсхүл парламентын бүрэн эрхийн хугацаа дуусахаас зургаан сарын өмнө энэ эрхээ хэрэгжүүлэхгүй. |
| 6 | Киргиз | Үндсэн хууль:<br>64.1.Ерөнхийлөгч:<br>1.Үндсэн хуульд заасны дагуу Жогорку Кенеш (Парламент)-ийн ээлжит сонгууль болон Үндсэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу Жогорку Кенешийн ээлжит бус сонгуулийг товлон зарлах;<br>2.Орон нутгийн хурлын сонгуулийн тов зарлах, хуульд заасан үндэслэл, журмын дагуу орон нутгийн хурлыг тараах эрхтэй.<br>64.2. Ерөнхийлөгч:<br>1.Жогорку Кенешийн хуулийг зарлан тунхаглах, хориг тавих эрхтэй;<br>2.Тулгамдсан асуудлаар Жогорку Кенешийн онцгой хуралдаан зарлан хуралдуулах эрхтэй;<br>3.Жогорку Кенешийн хуралдаанд үг хэлэх эрхтэй.<br>64.3.Ерөнхийлөгч: |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 1.Шүүхийн томилгооны хорооны саналаар Дээд шүүхийн шүүгчдийг сонгуулахаар Жогорку Кенешт өргөн барих;<br>2.Шүүхийн зөвлөлийн санал болгосноор Дээд шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэхээр Жогорку Кенешт өргөн барих;<br>3.Шүүхийн томилгооны хорооны саналаар орон нутгийн шүүхийн шүүгчдийг томилох;<br>4.Үндсэн хуульд заасан тохиолдолд Шүүхийн зөвлөлийн санал болгосноор орон нутгийн шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх эрхтэй.<br>64.4.Ерөнхийлөгч:<br>1.Ерөнхий прокурорыг Жогорку Кенештэй зөвшилцөн томилно. Хуульд заасны дагуу Ерөнхийлөгч Жогорку Кенешийн нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар зөвшөөрсний дагуу Ерөнхий прокурорыг албан тушаалаас нь чөлөөлөх, эсхүл Жогорку Кенешийн нийт гишүүдийн 1/3-ийн санаачилснаар Жогорку Кенешийн нийт гишүүдийн 2/3-ын саналаар батална. Ерөнхий прокурорын саналаар түүний орлогчийг томилох ба чөлөөлөх;<br>2.Засгийн газрын гишүүн, Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн байгууллагын дарга, түүний орлогчийг томилох ба чөлөөлөх эрхтэй.<br>64.5.Ерөнхийлөгч:<br>1.Үндэсний банкны даргад нэр дэвшигчийг Жогорку Кенешт өргөн барих, Үндэсний банкны даргын саналаар Үндэсний банкны зөвлөлийн орлогч дарга, гишүүдийг томилох, хуульд заасан журмын дагуу албан тушаалаас нь чөлөөлөх;<br>2.Сонгууль, санал асуулгын төв хорооны гишүүдийн 1/3-ийг томилох, чөлөөлүүлэхээр Жогорку Кенешт өргөн барих;<br>3.Данс тооцооны танхимын ((Chamber of Account) Аудит) гишүүдийн 1/3-т нэр дэвшигчдийг томилж, чөлөөлүүлэхээр Жогорку Кенешт өргөн барих;<br>4.Данс тооцооны танхимын гишүүдийн дундаас танхимын даргыг Жогорку Кенештэй зөвшилцөн томилох ба хуульд заасан журмын дагуу албан тушаалаас нь чөлөөлөх эрхтэй.<br>64.6.Ерөнхийлөгч:<br>1.Бүгд Найрамдах Киргиз Улсыг дотоод, гадаадад төлөөлөх;<br>2.Ерөнхий сайдтай зөвшилцөн гэрээ хэлэлцээрт оролцох, олон улсын гэрээнд гарын үсэг зурах, Ерөнхий сайд, Засгийн газрын бусад гишүүдэд энэ эрх мэдлийг шилжүүлэх;<br>3.Соёрхон баталсан, нэгдэн орсон тухай баримт бичигт гарын үсэг зурах; |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 4.Ерөнхий сайдтай зөвшилцөн Бүгд Найрамдах Киргиз Улсын дипломат төлөөлөгч, олон улсын байгууллагын байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах, гадаадын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх жуух бичиг, түүнийг эгүүлэн татах тухай захидлыг хүлээн авах эрхтэй.<br>64.7.Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Киргиз Улсын иргэний харьяалал олгох, эсхүл цуцлах эрхтэй.<br>64.8.Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Киргиз Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба Зэвсэгт хүчний дээд командлагчдыг томилж, чөлөөлнө.<br>64.9.Ерөнхийлөгч:<br>1.Батлан хамгаалах зөвлөлийг хуульд заасны дагуу байгуулж, даргалах;<br>2.Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд тусгайлан заасны дагуу шаардлагатай бол бүс нутгуудад урьдчилан мэдэгдэлгүйгээр онц байдал зарлах, энэ талаар Жогорку Кенешт нэн даруй мэдэгдэх;<br>3.Бүгд Найрамдах Киргиз Улсын эсрэг халдлага гарсан бол дайны байдал зарлах асуудлыг Жогорку Кенешт нэн даруй өргөн барих, бүх нийтийн болон хэсэгчилсэн дайчилгаа зарлах;<br>4.Улс орны бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс онц байдал зарлаж нэн даруй Жогорку Кенешээр хэлэлцүүлэх эрхтэй.<br>64.10.Ерөнхийлөгч:<br>1.Бүгд Найрамдах Киргиз Улсын төрийн шагнал олгох;<br>2.Бүгд Найрамдах Киргиз Улсын хүндэт цол олгох;<br>3.Цэргийн өндөр цол, дипломат цол, бусад тусгай цол олгох;<br>4.Өршөөл үзүүлэх;<br>5.Өөрийн ажлын албаны бүтцийг тодорхойлж, ажлын албаны даргыг томилох журмыг батлах эрхтэй.<br>64.11.Үндсэн хуульд заасан бусад эрх мэдлийг хэрэгжүүлнэ.<br>65.Ерөнхийлөгч зарлиг, захирамж гаргах замаар өөрийн бүрийн эрхийг Бүгд Найрамдах Киргиз Улсын нийт нутаг дэвсгэрт хэрэгжүүлнэ. |
| 7 | Латви | Үндсэн хууль:<br>41.Ерөнхийлөгч олон улсын харилцаанд улсаа төлөөлнө. Латви улсын дипломат төлөөлөгчдийг томилох ба бусад улсын дипломат төлөөлөгчдийг хүлээн авна. Парламентын шийдвэрээр хэрэгжүүлэх олон улсын гэрээг соёрхон батална. |

UIH.MN
ГҮЙЛГЭЭНИЙ САН

| | | |
|---|---|---|
| | | 42.Ерөнхийлөгч Латви Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Дайны үед Ерөнхийлөгч дээд командлагчийг томилно.<br>43.Ерөнхийлөгч Парламентын шийдвэрийг үндэслэн дайны байдал зарлана.<br>45.Шүүхээр гэм буруутайд тооцогдсон этгээдэд холбогдох хуулийг үндэслэн уучлал үзүүлэх эрхтэй.<br>46.Ерөнхийлөгч Засгийн газрын ээлжит бус хуралдааныг зарлах, даргалах, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох эрхтэй.<br>47.Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй.<br>48.Ерөнхийлөгч Парламентыг тараах санал гаргах эрхтэй. Саналын дагуу бүх нийтийн санал асуулга явуулна. Санал асуулгад оролцогчдын талаас илүү хувь нь парламентыг тараах саналыг дэмжвэл парламент тарсанд тооцно. Парламент тарснаас хойш хоёр сараас ихгүй хугацааны дараа шинэ сонгуулийг товлон зарлана.<br>49.Парламентыг тараах, эгүүлэн татах бол шинээр сонгогдсон парламентыг зарлан хуралдуулах хүртэл өмнөх парламентын гишүүдийн эрх хүчинтэй байх боловч зөвхөн Ерөнхийлөгчийн хүсэлтээр хуралдана. Энэ хуралдааны хэлэлцэх асуудлыг Ерөнхийлөгч тогтооно. |
| 8 | Македон | Үндсэн хууль:<br>75.Хуулийг Ерөнхийлөгч болон Ассамблейн ерөнхийлөгч хамтран гарын үсэг зурж, тунхаглана. Ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурахгүй байх шийдвэр гаргаж болно. Ассамблей хуулийг дахин хэлэлцэж нийт гишүүдийн олонхын саналаар баталсан тохиолдолд Ерөнхийлөгч гарын үсэг зурж зарлан тунхаглана. Хуулийг нийт гишүүдийн гуравны хоёр баталсан тохиолдолд Ерөнхийлөгч гарын үсэг зуран зарлан тунхаглах үүрэгтэй.<br>79.Ерөнхийлөгч Македон Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>80.Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.<br>84.Ерөнхийлөгч нь Македон Улсад суух гадаад орны дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичиг хүлээн авна.<br>Ерөнхийлөгч хуульд заасны дагуу улсын цол хүртээнэ.<br>Ерөнхийлөгч хуульд заасны дагуу уучлал үзүүлнэ.<br>Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.<br>Засгийн газрын бүрэлдэхүүнийг тодорхойлох эрхийг Ерөнхийлөгч олгоно.<br>Македон Улсын Ерөнхийлөгч нь Македон Улсаас гадаад улсад суух элчин сайд болон төлөөлөгчдийг зарлиг гарган итгэмжилж, эгүүлэн татна. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 86.Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч нь Бүгд найрамдах улсын Аюулгүй байдлын зөвлөлийн дарга мөн.<br>90.Ассамблей бүтэц зохион байгуулалтынхаа асуудлыг шийдэж дууссаны дараа 10 хоногт багтааж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг сонгуульд ялж Ассамблейд олонх болсон нам эвсэлд, эсхүл нам эвслийн санал болгосон нэр дэвшигч (Ерөнхий сайд болох)–д олгоно.<br>119.Македон Улсын Ерөнхийлөгч нь Македон Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна. Хуулиар заасны дагуу олон улсын гэрээг Засгийн газар байгуулж болно.<br>124.Дайны байдлыг Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл доод тал нь 30 гишүүний саналаар парламентын нийт гишүүдийн 2/3-ын саналаар зарлана. Парламент хуралдах боломжгүй бол дайны байдлыг Ерөнхийлөгч зарлаж, Парламентыг хуралдмагц батлуулна.<br>Парламентын дэгийн тухай хууль:<br>Анхны чуулганыг Ерөнхийлөгч зарлаагүй тохиолдолд чуулганыг сонгууль явагдсанаас хойш 21 хоногийн дотор хамгийн ахмад гишүүн зарлан хуралдуулна. [24] |
| 9 | Серби | Үндсэн хууль:<br>97.2.Ерөнхийлөгч эрүүгийн гэмт хэрэгт өршөөл болон уучлал үзүүлнэ.<br>99.5.Ерөнхийлөгч энхийн гэрээ байгуулах, дайн болон онц байдал зарлах эрхтэй.<br>105.Ерөнхийлөгч Үндэсний Ассамблей (Парламент)-н нийт гишүүдийн олонхын саналаар олон улсын гэрээ хэлэлцээр байгуулна.<br>112.Ерөнхийлөгч Серби Улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна;<br>Ерөнхийлөгч өршөөл үзүүлэх болон цол хүртээнэ;<br>Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний командлагч бөгөөд Сербийн армийн албан хаагчдыг томилох, дэвшүүлэх болон чөлөөлөх эрхтэй;<br>Ерөнхийлөгч Серби Улсыг гадаад болон дотооддоо төлөөлнө;<br>Ерөнхийлөгч Засгийн газрын саналыг үндэслэж, Серби Улсаас гадаад улсад суух элчин сайдуудыг зарлиг гарган томилох болон эгүүлэн татна.<br>Үндсэн хуульд заасан бусад асуудлыг шийдвэрлэнэ. |

[24] http://parliament.am/library/kanonakarger/MACEDONIA.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 113.Ерөнхийлөгч хуулийг тунхаглан зарлиг гаргах, эсхүл хуулийг баталснаас хойш 15 хоногоос хэтрэлгүй, онцгой журмаар баталсан бол 7 хоногоос хэтрэлгүй Үндэсний Ассамблейгаар дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.<br>Буцаагдсан хуулиар дахин санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд нийт гишүүдийн олонхын саналаар батална. Иймхүү батлагдсан хуулийг Ерөнхийлөгч тунхаглан зарлах үүрэгтэй байна. Үндсэн хуульд заасан хугацаанд Ерөнхийлөгч тус хуулийг тунхаглан зарлаж зарлиг гаргаагүй бол, Парламентын спикер зарлиг гаргана.<br>116.Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгохгүй.<br>127.Ерөнхийлөгч төлөөлөгчдийн саналыг харгалзан үзсэний үндсэн дээр өөрийн санал болгосон Ерөнхий сайдад нэр дэвшигчийг парламентаар хэлэлцүүлнэ.<br>172.Үндсэн хуулийн шүүх нь 15 шүүгчтэй байх бөгөөд 9 жилийн хугацаагаар томилох болон сонгоно. Үндсэн хуулийн шүүхийн 5 шүүгчийг Үндэсний Ассамблей, 5 шүүгчийг Ерөнхийлөгч, мөн 5 шүүгчийг Кассацийн дээд шүүхийн хуралдаанаар томилно.<br>Үндэсний Ассамблей нь Үндсэн хуулийн дээд шүүхийн 5 шүүгчийг Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн 10 нэр дэвшигч дундаас, Ерөнхийлөгч нь Үндэсний Ассамблейгаас нэр дэвшүүлсэн 10 нэр дэвшигч дундаас, Кассацийн дээд шүүх нь Дээд шүүх болон Улсын прокурорын зөвлөлөөс нэр дэвшүүлсэн 10 шүүгч дундаас тус тус томилно. |
| 10 | Сингапур | Үндсэн хууль:<br>21.2.10.Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд заасны дагуу бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.<br>22.Үндсэн хуульд заасан бусад заалтыг үл харгалзан, Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу зөвшилцөж, эсхүл зөвлөлдөн гаргана гэсэн заалтад санал нь нийлээгүй тохиолдолд Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд дараах албан тушаалд томилохоос татгалзах, эсхүл эгүүлэн татахаас татгалзах эрхтэй байна:<br>а)Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Дээд шүүхийн шүүгчид, Шүүхийн комиссарууд<br>22.1.Ерөнхийлөгч тухайн нөхцөл бүрдсэн тохиолдолд, Кабинетын зөвлөсний үндсэн дээр:<br>а) Гэмт хэрэгтнийг яллахад шаардагдах мэдээлэл өгсөн гэмт хэргийн хамсаатанд уучлал үзүүлнэ;<br>б) Гэмт этгээдэд Сингапурын аль ч шатны шүүхэд өмгөөллийн үйлчилгээг үнэгүй, эсхүл хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу олгох, таслан шийдвэрлэх тогтоолыг тохиромжтой хугацаагаар, эсхүл бүр мөсөн хойшлуулах эрхтэй;<br>в) Ял, торгууль, эсхүл эд хөрөнгө хураахыг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь чөлөөлнө. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 22.2.Ямарваа нэгэн гэмт хэрэгтэн нь цаазын ялаар шийтгүүлж, тус ял нь давж заалдах шатны шүүхэд хэрэгсэхгүй болсон нөхцөлд Ерөнхийлөгч нэгдүгээр хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах материалыг шаардах эрхтэй байна.<br>25.Ерөнхий сайдыг томилно.<br>Ерөнхийлөгч парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр парламентын гишүүд дундаас сайд нарыг томилно. Ингэхдээ парламент тарсан үед томилгоо хийхдээ өмнөх парламентын гишүүнийг томилж болох ба тэрээр шинэ парламентын анхны хуралдаан явагдсанаас хойш, тухайн Парламентын гишүүн бус нөхцөлд албан үүргээ үргэлжлүүлэх эрхгүй байна.<br>Энэхүү зүйлд заасан томилгоог Ерөнхийлөгч хийх бөгөөд Төрийн тамгаар баталгаажуулна.<br>35.1.Ерөнхий прокурорын албаны бүтэц болон томилгоог Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын зөвлөгөөг зөвшөөрснөөр Дээд шүүхийн шүүгчээр томилогдох болзлыг хангасан этгээд дундаас томилно.<br>95.1.Дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчдийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай зөвшилцөн томилно.<br>95.2.Ерөнхий шүүгчээс бусад шүүгчийг томилох саналыг Ерөнхий сайд Дээд шүүхийн ерөнхий шүүгчтэй зөвшилцөн гаргана.<br>100.Ерөнхийлөгч нь доод тал нь Дээд шүүхийн 3 шүүгчээс бүрдэх шүүхэд Үндсэн хуулийн зүйл, заалттай холбоотой асуудлаар, эсхүл гарч магадгүй гэсэн асуудлаар саналыг нь асуух эрхтэй байна.<br>148.Ерөнхийлөгч нь төсвийн төслийг батлахад Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөгөөг үл харгалзан зөвшөөрлөө өгөөгүй тохиолдолд, Парламентын дийлэнх олонхын саналаар төсвийн төслийг тогтоол гарган батална. Тогтоол гарснаар Ерөнхийлөгчийн зөвшөөрөл олгогдсонд тооцно. |
| 11 | Словак | Үндсэн хууль:<br>82.2.Үндэсний зөвлөл (парламент)-ийн нээлтийн чуулганыг Словак Улсын Ерөнхийлөгч сонгуулийн дүн зарласнаас хойш 30 хоногийн дотор зарлана. Эсхүл Үндэсний зөвлөл нь сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 13 дахь өдөр хуралдана.<br>84.Олон улсын гэрээг 7.3, 7.4-р заалтад заасны дагуу болон Ерөнхийлөгчөөс буцаагдсан хуулийг парламентын нийт гишүүдийн олонхын саналаар тус тус батална.<br>4.Дайн зарлах асуудлыг парламентын нийт гишүүдийн 3/5-ын саналаар шийдвэрлэнэ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 87.Ерөнхийлөгч хуулийг парламентад тайлбарын хамт буцаасан тохиолдолд, парламент дахин хэлэлцэж баталсан бол зарлан тунхагласанд тооцно.<br>Хуулийг Ерөнхийлөгч, парламентын дарга болон Ерөнхий сайд хамтран гарын үсэг зурж батламжлах бөгөөд буцаагдсан хуулийг парламент баталж, Ерөнхийлөгч гарын үсэг зураагүй бол, Ерөнхийлөгч гарын үсэг зураагүйг үл харгалзан хүчинтэйд тооцно.<br>102.Ерөнхийлөгч:<br>1.Бүрэн эрхт дипломат төлөөлөгчдийн тэргүүнийг хүлээн авах, итгэмжлэх, эгүүлэн татах эрхтэй байна.<br>2.Зэвсэгт хүчний командлагч байна.<br>3.Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг, Үндсэн хуулийн<br>шүүхийн дарга, дэд даргыг томилж, чөлөөлнө, Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн болон Ерөнхий прокурорын тангаргийг өргүүлнэ.<br>4.Бусдад энэ эрхээ шилжүүлээгүй бол улсын цол хүртээнэ.<br>5.Словак Улсын Засгийн газрын саналын дагуу цэргийн дайчилгаа зарлах, дайны байдал зарлах, эсхүл онц байдал зарлах болон цуцлах эрхтэй байна.<br>6.Шүүгч, Словак Улсын Ерөнхий шүүгч Ерөнхий шүүгчийн орлогчийг, Ерөнхий прокурор болон Шүүхийн зөвлөлийн гурван гишүүнийг томилж, чөлөөлнө, шүүгчийн тангаргийг өргүүлнэ.<br>7.Уучлал, эсхүл өршөөл хэлбэрээр эрүүгийн хэргийн шүүхээр ногдуулсан шийтгэлийг бууруулах буюу хэргийг хэрэгсэхгүй болгоно.<br>103.Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр дараалан хоёроос дээш удаа сонгохгүй.<br>110.Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг томилж, чөлөөлнө.<br>111.Ерөнхийлөгч Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх ба тэдэнд яамдыг удирдах бүрэн эрх олгоно. |
| 12 | Турк | Үндсэн хууль:<br>89.Ерөнхийлөгч Үндэсний Их Хурлаар батлагдсан хуулийг 15 хоногийн дотор зарлан тунхаглана.<br>Ерөнхийлөгч хуулийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь зарлан тунхаглах боломжгүй гэж үзсэн бол тайлбарын хамт Үндэсний Их Хуралд заасан хугацаанд дахин хэлэлцүүлэхээр буцаана. Хэсэгчлэн буцаасан тохиолдолд Ерөнхийлөгч болон Үндэсний Их Хурал тухайн асуудлыг хэлэлцэж болно. Төсвийн тухай хуулиуд дээрхид хамаарахгүй. |

UIH.MN ГУЛААН САНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | Ерөнхийлөгчийн буцаасан хуулийг Үндэсний Их Хурал ямарваа нэгэн өөрчлөлтгүй баталбал хуулийг Ерөнхийлөгч тунхаглан зарлана. Өөрчлөлт оруулж баталсан тохиолдолд Ерөнхийлөгч буцаах эрхтэй байна.<br>92.Үндэсний Их Хурал нь дайны байдал зарлах эрхтэй байна. Үндэсний Их Хурал завсарласан үед улс орны бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдсан үед Ерөнхийлөгч Туркийн зэвсэгт хүчнийг хөдөлгөх шийдвэр гаргана.<br>93.Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар, эсхүл Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр ээлжит бус чуулган зарлана. Мөн Үндэсний Их Хурлын дарга өөрийн хүсэлтээр, эсхүл гишүүдийн 1/5-ийн бичгээр гаргасан хүсэлтээр ээлжит бус чуулган зарлана.<br>101.Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.<br>104.Ерөнхийлөгч Турк Улсаас гадаад улсад суух төлөөлөгчдийг итгэмжлэх бөгөөд Турк Улсад томилогдсон гадаад орны төлөөлөгчдийг хүлээн авна.<br>Ерөнхийлөгч тодорхой этгээдүүдэд (хүнд өвчин, хөгжлийн бэрхшээл, эсхүл өндөр насыг харгалзан) шүүхээр ногдуулсан шийтгэлийг бууруулах болон хэрэгсэхгүй болгоно.<br>Ерөнхийлөгч Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг зарлан хуралдуулна.<br>Ерөнхийлөгч Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг даргална.<br>Ерөнхийлөгч Туркийн зэвсэгт хүчний командлагчийн үүргийг гүйцэтгэнэ.<br>Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг, Төрийн зөвлөлийн гишүүдийн 1/4-ийг, Ерөнхий прокурор болон Давж заалдах шатны шүүхийн Дэд прокурор, Цэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг, Цэргийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийг болон Шүүх, прокурорын дээд зөвлөлийн гишүүдийг тус тус томилно.<br>Ерөнхийлөгч олон улсын гэрээ байгуулна.<br>Ерөнхийлөгч Турк Улсаас гадаад улсад суух төлөөлөгчдийг итгэмжлэх, мөн Турк Улсад гадаад улсаас томилогдсон төлөөлөгчдийг хүлээн авна.<br>Ерөнхийлөгч Үндсэн хууль болон бусад хуульд заасан сонгох, томилох болон бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.<br>109.Сайд нарын зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг парламентын гишүүдээс томилно.<br>Ерөнхий сайд нь сайд нарыг парламентын гишүүдээс, эсхүл парламентын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно. |

| | | |
|---|---|---|
| | | 146.Үндсэн хуулийн шүүх нь 17 гишүүнтэй байна.<br>Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч нь дараах шүүхийн дарга болон гишүүд дундаас:<br>-3 шүүгчийг Давж заалдах шатны шүүхээс,<br>-2 шүүгчийг Төрийн зөвлөл,<br>-1 шүүгчийг Цэргийн дээд шүүхээс,<br>-1 шүүгчийг Цэргийн захиргааны дээд шүүхээс тус бүр 3 нэр дэвшигч дундаас холбогдох нэгдсэн хуралдаанаар томилно.<br>-3 шүүгчийг Боловсролын дээд хорооноос,<br>-4 шүүгчийг Хорооны гишүүн бус хууль, эдийн засаг, улс төрийн салбарын багш нараас,<br>-1 шүүгчийг төрийн дээд албан тушаалтнаас<br>-1 шүүгчийг хувиараа өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэгчдээс,<br>-1 шүүгчийг нэгдүгээр зэргийн шүүгч, прокурор, эсхүл Үндсэн хуулийн илтгэгч дундаас тус тус томилно.<br>154. Ерөнхийлөгч Улсын Ерөнхий прокурор болон түүний орлогчийг 4 жилийн хугацаагаар томилно. |
| 13 | Унгар | Үндсэн хууль:<br>9.3.Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг эдэлнэ:<br>а) Унгар Улсыг төлөөлөх;<br>б) Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцох, үг хэлэх;<br>в) Хууль хэрэгжүүлэх;<br>г) Ард нийтийн санал асуулга явуулах санаачилга гаргах;<br>д) Үндэсний Ассамблей, орон нутгийн болон хотын захирагчийн сонгуулийг товлон зарлах, мөн Европын парламентын сонгууль, бүх ард түмний санал асуулгыг товлон зарлах;<br>е) Онцгой хуулийн асуудлыг шийдвэрлэх;<br>ё) Шинэ Үндэсний Ассамблейн анхдугаар хуралдааныг товлон зарлах;<br>ж) Үндэсний Ассамблейг тараах;<br>з) Батлагдсан Үндсэн хууль, эсхүл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа, эсэхийг Үндсэн хуулийн шүүхээр хянуулах, батлагдсан хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа, эсэхийг Үндсэн хуулийн шүүхээр хянуулах, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Үндэсний Ассамблейд буцаах; |

UIH.MN
ЧУУЛГАНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | и) Ерөнхий сайд, Кури (Дээд шүүх)-гийн Ерөнхийлөгч, Шүүхийн Үндэсний удирдах байгууллагын Ерөнхийлөгч, Ерөнхий прокурор, Үндсэн эрхийн асуудал хариуцсан Парламентын тусгай эрхт төлөөлөгчид нэр дэвшигчийг санал болгох;<br>й) Мэргэжлийн шүүгч нарыг болон Төсвийн зөвлөлийн Тэргүүнийг томилох;<br>к) Унгарын Шинжлэх ухааны академи, Унгарын Урлагийн академийн Ерөнхийлөгчийг батлах;<br>л) Өөрийн Тамгын газрыг зохион байгуулах.<br>9.4. Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг эдэлнэ:<br>а) Парламент, эсхүл Засгийн газрын бүрэн эрхэд үндэслэн олон улсын шинжтэй гэрээг батламжлах;<br>б) Гадаад улсын бүрэн эрхт элчин сайд, төлөөлөгчийг итгэмжлэх, хүлээн авах;<br>в) Сайд нар, Унгарын Үндэсний банкны Ерөнхийлөгч, бие даасан зохицуулах байгууллагуудын гүйцэтгэх захирлууд, их сургуулийн профессоруудыг томилох;<br>г) Их сургуулийн захирлуудыг томилох;<br>д) Генералуудыг томилох, генерал цол олгох;<br>е) Хуулиар тогтоосон улсын цол олгох, одон, медалиар шагнах ба гадаад улсын төрийн шагналыг ашиглахыг зөвшөөрөх;<br>ё) Өршөөл үзүүлэх;<br>ж) Өөрийн эрх, үүргийн хүрээнд нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;<br>з) Иргэнийг харьяат болох, харьяатаас гарахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;<br>и) Хуулиар тогтоосон бусад асуудлыг шийдвэрлэнэ. |
| 14 | Финланд | Үндсэн хууль:<br>57. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.<br>58. Ерөнхийлөгч Засгийн газрын саналыг үндэслэн шийдвэр гаргана. Хэрэв Ерөнхийлөгч Засгийн газрын саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол тухайн асуудлыг Засгийн газарт буцаана. Хэрэв Ерөнхийлөгчийн эс зөвшөөрсөн асуудал нь албан тушаалтныг томилох, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад асуудал байвал Засгийн газар Парламентад танилцуулна. Үүний дараа Засгийн газрын санал болгосны дагуу Парламент Засгийн газраас танилцуулсан тайланг үндэслэн шийдвэр гаргана.<br>Ерөнхийлөгч дараах асуудлын талаар шийдвэр гаргахдаа Засгийн газрын саналыг үл харгалзана:<br>1.Засгийн газар, сайд нарыг томилох, огцруулах; |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 2.Парламентын ээлжит бус сонгуультай холбоотой зарлиг гаргах;<br>3.Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх, хуульд тусгайлан заасан хувь хүнтэй холбоотой асуудлаар, эсхүл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй асуудлаар шийдвэр гаргах;<br>4.Аландын арлуудын автономит эрхтэй холбоотой асуудал болон Аландын арлуудтай холбоотой санхүүгийн асуудлаар шийдвэр гаргах.<br>Засгийн газрын сайд нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний асуудлыг Ерөнхийлөгчид танилцуулна. Засгийн газрын илтгэгч нь Засгийн газрын үйл ажиллагаа, Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах талаар Ерөнхийлөгчид танилцуулна.<br>Ерөнхийлөгч хуульд тусгайлан заасан цэргийн дүрэм журамтай холбоотой асуудлаар холбогдох сайдтай хамтран шийдвэр гаргана. Мөн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь цэргийн томилгоо, Ерөнхийлөгчийн Тамгын газартай холбоотой асуудлаар шийдвэр гаргана. Тусгайлан гаргасан хуулийн дагуу Финланд улсын оролцоотой зэвсэгт хүчний удирдлагатай холбоотой шийдвэр гаргана. |
| 15 | Хорват | 94.Ерөнхийлөгч нь Хорват Улсыг өөрийн оронд болон гадаад улсад төлөөлнө. Ерөнхийлөгч төрийн удирдлагын үйл ажиллагаа, тогтвортой байдлын нэгдлийг байнга хангана.<br>98.Ерөнхийлөгч дараах бүрэн эрхтэй:<br>-Парламентын сонгуулийг зарлах, анхдугаар чуулганыг зарлан хуралдуулах;<br>-Үндсэн хуульд нийцүүлэн ард нийтийн санал асуулга явуулах;<br>-Парламентад авсан суудлын тоонд үндэслэн парламентын олонхын итгэлийг авсан этгээдэд Засгийн газар байгуулах эрхийг олгох буюу Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх;<br>-Уучлал үзүүлэх;<br>-Шагнал олгох;<br>-Үндсэн хуульд заасан бусад эрх. |
| 16 | Монтенегро | Үндсэн хууль:<br>90.Ерөнхийлөгч Засгийн газар, эсхүл парламентын гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар парламентын ээлжит бус чуулганыг зарлана.<br>94.Ерөнхийлөгч хуулийг баталснаас хойш 7 хоногийн дотор, яаралтай журмаар батлагдсан хуулийг 3 хоногийн дотор зарлах, эсхүл парламентад дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй байна. Ерөнхийлөгч дахин батлагдсан хуулийг тунхаглан зарлах үүрэг хүлээнэ. |

UIH.MN
ЧУУЛГАНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 95.Ерөнхийлөгч:<br>-Гадаад орны дипломатуудыг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичиг хүлээн авна. Ерөнхийлөгч Чрна Гора Улсыг гадаадад болон дотоодод төлөөлнө.<br>-Ерөнхийлөгч Батлан хамгаалах болон Аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу зэвсэгт хүчнийг командална.<br>-Ерөнхийлөгч нь Чрна Гора Улсаас гадаад улсад суух дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг парламентын гадаад харилцааны асуудал хариуцсан хорооны саналыг үндэслэн Засгийн газартай зөвшилцөж томилох, эгүүлэн татах эрхтэй байна.<br>-Чрна Гора Улсын медалиар шагнах болон цол хүртээх эрхтэй байна.<br>-Өршөөл үзүүлнэ.<br>Ерөнхийлөгч Үндсэн хууль болон бусад хуульд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.<br>97.Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь хоёр удаа сонгож болно.<br>103.Ерөнхийлөгч нь парламентыг сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшигчийг санал болгоно.<br>Ерөнхий сайдад нэр дэвшигч нь парламентад мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг танилцуулна.<br>Парламент нь нэгэн зэрэг нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг шийдвэрлэнэ.<br>124.Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Чрна Гора Улсын Ерөнхийлөгч, Парламентын спикер болон Ерөнхий сайдын хамтарсан саналын дагуу парламент томилж, чөлөөлнө. Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг 30 хоногийн дотор томилж чадаагүй бол парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн томилно.<br>131.Батлан хамгаалах болон Аюулгүй байдлын зөвлөл нь Ерөнхийлөгч, Парламентын спикер болон Ерөнхий сайдаас бүрдэнэ.<br>Ерөнхийлөгч нь Батлан хамгаалах болон Аюулгүй байдлын зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ. |
| 17 | Эстони | Үндсэн хууль:<br>78.Ерөнхийлөгч:<br>1.олон улсын харилцаанд Бүгд найрамдах улсыг төлөөлнө;<br>2.Бүгд Найрамдах Эстони Улсын дипломат төлөөлөгчдийг томилох, эгүүлэн татах, Эстони Улс дахь дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх жуух бичгийг хүлээн авах; |

UIH.MN
ЧУУЛГАНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 3.Парламентын ээлжит сонгууль зарлах, Үндсэн хуулийн 89, 97, 105, 119 дүгээр зүйлийг үндэслэн парламентын ээлжит бус сонгууль зарлах;<br>4.Үндсэн хуулийн 66-д заасны дагуу парламентын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулах, нээх;<br>5.Үндсэн хуулийн 68-д заасны дагуу парламентын даргын хүсэлтээр ээлжит чуулганыг зарлах;<br>6.Үндсэн хуулийн 105, 107-д заасны дагуу хуулийг зарлан тунхаглах;<br>7.Үндсэн хуулийн 109, 110-д заасны дагуу зарлиг гаргах;<br>8.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;<br>9.Үндсэн хуулийн 89-д заасны дагуу Ерөнхий сайдад нэр дэвшигчийг санал болгох;<br>10.Үндсэн хуулийн 89, 90, 92 дугаар зүйлийг үндэслэн Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын санал болгосноор томилох;<br>11.Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Эстонийн төв банкны зөвлөлийн дарга, Ерөнхий аудитор, Хууль зүйн канцлерыг (Chancellor of Justice) парламентад санал болгох;<br>12.Эстонийн төв банкны зөвлөлийн санал болгосноор Эстонийн төв банкны Ерөнхийлөгчийг томилох;<br>13.Улсын Дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийг томилох;<br>14.Төрийн шагнал, цэргийн болон дипломат цол олгох;<br>15.Эстони Улсын батлан хамгаалахын дээд командлагч байна;<br>16.Үндсэн хуулийн 129-д заасны дагуу парламентын санал болгосноор дайны байдал зарлах, цэрэгт дайчлах, цэргээс халах зарлиг гаргах, онц байдал зарлах;<br>17.Үндсэн хуулийн 128-д заасны дагуу Эстони Улсын эсрэг түрэмгийлэл гарсан бол дайны байдал зарлах, цэрэгт дайчлах тухай зарлах;<br>18.Шүүхээр гэм буруутайд тооцогдсон этгээдэд түүний хүсэлтийг үндэслэн уучлал, өршөөл үзүүлэх;<br>19.Хууль зүйн канцлерын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх эрхтэй. |
| 18 | Япон | Үндсэн хууль:<br>4.Эзэн хаан зөвхөн Үндсэн хуульд заасан асуудлаар төрийн үйл хэрэгт оролцох ба Засгийн газартай холбоотой өөр бүрэн эрх хэрэгжүүлэхгүй. Эзэн хаанаас төрийн үйл хэргээ төлөөлүүлэхийг хуулиар тогтоож болно.<br>6.Эзэн хаан парламентаас өргөн мэдүүлснээр Ерөнхий сайдыг томилно.<br>7.Эзэн хаан Засгийн газрын зөвлөж зөвшөөрсний дагуу дараах төрийн үйл хэргийг хэрэгжүүлнэ:<br>1.Үндсэн хуулийн нэмэлт, бусад хууль, Засгийн газрын тогтоол, олон улсын гэрээг соёрхон батлах; |

IIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 2.Парламентын хуралдааныг зарлан хуралдуулах;<br>3.Төлөөлөгчдийн танхимыг тараах;<br>4.Парламентын сонгуулийг товлон зарлах;<br>5.Төрийн сайд нар, хуульд заасан бусад албан тушаалтан, бүрэн эрхт төлөөлөгч, элчин сайд нарыг томилох, чөлөөлөх, тангараг өргүүлэх;<br>6.Ерөнхий болон тусгай өршөөл үзүүлэх, ял шийтгэлийг хөнгөрүүлэх, ялын хугацаа хойшлуулах, эрх сэргээх;<br>7.Цол хэргэм олгох;<br>8.Дипломат баримт бичгийг хуульд заасны дагуу соёрхон батлах;<br>9.Гадаадын элчин төлөөлөгч, сайд нарыг хүлээн авах;<br>10.Ёслолын бусад чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй. |

## ХАВСРАЛТ 2

**Үндсэн хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон үндсэн бүрэн эрхүүд**

| № | **Пунсалмаагийн Очирбат** | | **Нацагийн Багабанди** | | **Намбарын Энхбаяр** | **Цахиагийн Элбэгдорж** | | **Халтмаагийн Баттулга** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **1992** | **1993-1997** | **1997-2001** | **2001-2005** | **2005-2009** | **2009-2013** | **2013-2017** | **2017 оноос хойш** |
| 1 | **33.1.Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**<br>33.1.1/УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ-аар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ; | | | | | | | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| 2 | 33.1.2/ УИХ-д олонх суудал авсан намтай, аль ч нам олонхын суудал аваагүй бол УИХ-д суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах; | 33.1.2/ УИХ-д олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор УИХ-д оруулах;<br>*/2000 оны арванхоёрдугаар сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр* ***өөрчлөн найруулсан./*** | */2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр* ***хүчингүй болсонд тооцсон./*** |
| 3 | 33.1.3/өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно; | | |
| 4 | 33.1.4/гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, УИХ-тай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах; | | |
| 5 | 33.1.5/Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг УИХ-тай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах; | | |
| 6 | 33.1.6/Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах; | | |
| 7 | 33.1.7/улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах; | | |
| 8 | 33.1.8/уучлал үзүүлэх; | | |
| 9 | 33.1.9/Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх; | | |
| 10 | 33.1.10/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх; | | |
| 11 | 33.1.11/бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах; | | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| 12 | 33.1.12/Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол УИХ-ын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг УИХ уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв УИХ шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ХАВСРАЛТ 3

**Үндсэн хуулиар Монгол Улсын ерөнхийлөгчид олгосон бусад бүрэн эрхүүд**

<table>
<tr><th rowspan="2">№</th><th colspan="2">Пунсалмаагийн Очирбат</th><th colspan="2">Нацагийн Багабанди</th><th>Намбарын Энхбаяр</th><th colspan="2">Цахиагийн Элбэгдорж</th><th>Халтмаагийн Баттулга</th></tr>
<tr><th>1992</th><th>1993-1997</th><th>1997-2001</th><th>2001-2005</th><th>2005-2009</th><th>2009-2013</th><th>2013-2017</th><th>2017 оноос хойш</th></tr>
<tr><td>1</td><td colspan="3">22.2.УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ.</td><td colspan="4">22.2.УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ.<br>“Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах тухай шийдвэр гаргана.”<br>/2000 оны арванхоёрдугаар сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн./</td><td>22.2.УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөж санал болгосон бол УИХ-ын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.<br><br>/2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./</td></tr>
<tr><td>2</td><td colspan="7"></td><td>22.3.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | **анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор,** эсхүл Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу **Ерөнхий сайдыг огцруулснаас**, түүнчлэн 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос **хойш гуч хоногийн дотор УИХ Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч УИХ-ыг тараах** шийдвэр гаргана.<br>*/2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр **нэмсэн**./* |
| 3 | 26.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. | 26.1. Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.<br>*/2019 оны 1арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр **өөрчлөн найруулсан**./* |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| 4 | 27.3.УИХ-ын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, УИХ-ын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно. | |
| 5 | 27.4.УИХ-ын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг УИХ-ын дарга товлон зарлана. | |
| 6 | 31.7. Ерөнхийлөгчийг **зөвхөн нэг удаа улируулан сонгож болно** | */2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр* ***хүчингүй болсонд тооцсон****./* |
| 7 | 33.2.Ерөнхийлөгч Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. | |
| 8 | 33.3.Ерөнхийлөгч УИХ-д болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн таалллаар оролцон, улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно. | |
| 9 | 33.4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно. | 33.4.**Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно**.<br>*/Энэ хэсгийг 2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр* ***өөрчлөн найруулсан****./* |
| 10 | 39.2.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг | 39.2.Монгол Улсын **Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн** УИХ-д өргөн мэдүүлнэ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Ерөнхийлөгчтэй зөвшилцөн УИХ-д өргөн мэдүүлнэ. | Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол УИХ-д өөрөө **өргөн мэдүүлнэ.** <br> */2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр **өөрчлөн найруулсан**./* |
| 11 | 43.3.Улсын Их Хурал **Засгийн газрыг огцруулах** тухай өөрөө санаачилсан болон **Ерөнхийлөгчийн санал**, Ерөнхий сайдын мэдэглийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах, эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ | 33.1.УИХ-ын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал УИХ гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. УИХ-ын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай УИХ-ын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно. <br> */2019 оны арваннэгдүгээр сарын 14-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр **өөрчлөн найруулсан**./* |
| 12 | 51.2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг УИХ-д танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.; | |
| 13 | 56.2.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг УИХ-тай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.; | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| 14 | 65.1.1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг УИХ, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор УИХ зургаан жилийн хугацаагаар томилно. |

**1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхүүд** *2020.12.31-ний байдлаар*

| № | **Пунсалмаагийн Очирбат** | **Нацагийн Багабанди** | | **Намбарын Энхбаяр** | **Цахиагийн Элбэгдорж** | | **Халтмаагийн Баттулга** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **1993-1997** | **1997-2001** | **2001-2005** | **2005-2009** | **2009-2013** | **2013-2017** | **2017 оноос хойш** |
| 1 | **12 дугаар зүйл. Төрийн байгуулал, улс орны удирдлагын талаархи Ерөнхийлөгчийн бүрэн эрх**<br>12.1. УИХ-ын **анхдугаар чуулганыг товлон зарлах** буюу **улс орны** чанартай **хойшлуулшгүй чухал асуудлыг** хэлэлцүүлэхээр УИХ-ын **ээлжит бус чуулган** чуулахыг санаачилна. Ерөнхийлөгчийн санаачилгаар ээлжит бус чуулган чуулах бол **УИХ-ын дарга** Ерөнхийлөгчтэй **тохиролцсон** хугацаанд уул чуулганыг **товлон зарлана**. | | | | | | |
| 2 | 2.Засгийн газар огцорсон, УИХ Ерөнхий сайдыг огцруулах буюу хүсэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, УИХ-ын анхдугаар чуулганаар УИХ-ын дарга сонгогдсон, Ерөнхий сайд нас нөгчсөнөөс хойш 14 хоногийн дотор УИХ-д олонхи суудал авсан нам буюу намуудын сонгуулийн эвсэл (цаашид нам гэх)-тай, аль ч нам олонхийн суудал авахгүй бол УИХ-д суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар | | "2. УИХ-ын анхдугаар чуулганаар УИХ-ын дарга сонгогдсон, Засгийн газар огцорсон, УИХ Ерөнхий сайдыг огцруулах буюу хүсэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, Ерөнхий сайд нас нөгчсөн тохиолдолд УИХ-д олонхи суудал авсан нам буюу намуудын сонгуулийн эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол УИХ-д хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг | | | | “2.УИХ-д **олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг**; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхыг |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
